

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Хавсралт-1

| Шийд- вэрийн д/д | Заалт д/д | Шийдвэрийн нэр, огноо дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц | Биелэлт гаргах нэгж | Хувь |
|------------------------|--------------|---|---|---|------------------------|------|
| ЗГҮАМХөтөлбөр | | | | | | |
| 1 | 369 | Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай 2024-09-18 Дугаар 2024_01_1 | 2.1.1.. “Гашуунсухайт-Ганцмод”, “Ханги-Мандал”, “Шивээхүрэн-Сэхээ” хилийн боомтуудын хил дамнасан холболтын төмөр замын төсөл - Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал нарт;(2.Дараах бүтээн байгуулалтын төслүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж эхлүүлэхийг дараах Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар нарт:) | Шивээхүрэн-Сэхээ боомтын хил дамнасан нарийн царигийн төмөр замын бүтээн байгуулалтыг 2023 оны 05 дугаар сард эхлүүлсэн бөгөөд төмөр замын дээд, доод бүтэц, эрчим хүч, барилга байгууламж, дохиолол холбоо, гүүр хоолой, авто зам, ачиж буулгах терминал зэрэг төслийн барилга угсралтын ажлууд бүрэн дуусч 2024 оны 12 дугаар сард холбогдох Техникийн болон Улсын комиис ажиллаж уг төмөр замыг байнгын ашиглалтанд хүлээн авсан. Монголын талаас Хятадын төмөр замын Сэхээ өртөөтэй холбогдох барилга угсралтын ажил бүрэн дууссан. | “МТЗ”ТӨХК | 100% |
| | 376 | | 18.1. 1.1. Энэ албан даалгаврын 2.1.1-д заасан төслийг хэрэгжүүлэх хүрээнд “Гашуунсухайт-Ганцмод”, “Ханги-Мандал”, “Шивээ хүрэн-Сэхээ” хилийн боомтуудын хил дамнасан төмөр зам, ачаа тээврийн | Засгийн газрын 2022 оны 116 дугаар тогтоолын дагуу Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн, Хөөт-Чойбалсан, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх ажлыг Концессын тухай хуулийн хүрээнд 2023 оны 12 дугаар сар хүртэл зохион байгуулан ажилласан. Энэ хугацаанд төслүүдийг хэрэгжүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, тогтоолын дагуу Баруун, Зүүн чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх төрийн өмчийн оролцоотой хамтарсан компанийг байгуулж, Концессын гэрээний үндсэн | | |

| | | | | | | |
|--|--|--|---|--|-----------|------|
| | | | шилжүүлэн ачих терминалыг барих төслийг эрчимжүүлэх, Улаанбаатар төмөр замын төв коридорыг шинэчлэх ажлыг үргэлжлүүлэх, баруун, зүүн босоо тэнхлэгийн төмөр замын концесс эзэмшигчийг сонгон шалгаруулах ажлыг Эдийн засаг, хөгжлийн сайдтай хамтран зохион байгуулах | нөхцлүүдийг тохиролцох хэлэлцээ хийх хүртэл ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Үүнээс шалтгаалан Засгийн газрын 116 дугаар тогтоолын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд цаашид хэрэгжих хууль эрх зүйн боломжгүй болсон. 2024 оны 03 дугаар сард Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын төслийг ТХХТТХ-ийн дагуу хэрэгжүүлэх саналыг ЭЗХЯ-д хүргүүлсэн. Япон Улсын "Ниппон коей" компанийн 2013 онд боловсруулсан Эрэнцав-Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын инженерийн урьдчилсан зураг төсөлд эдийн засгийн тооцооллыг хийж, тооцооллыг үндэслэн Засгийн газрын 2023 оны 404 дүгээр тогтоолоор батлагдсан "Түншлэлийн хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам"-ын дагуу урьдчилсан үнэлгээг боловсруулж ЗТЯ-д 2025 оны 3-р сарын 17-д 01/13401 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | "МТЗ"ТӨХК | 100% |
|--|--|--|---|--|-----------|------|

"МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨХК

ХЯНАЛТЫН АЛБА

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ IV УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТ

2025.12.10

Хавсралт-2

| Д/д | Арга хэмжээ, зорилт | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2024 он/ | Зорилтот түвшин /Хэрэгжиж дуусах хугацаа/ | Хугацаа /I-IV улирал/ | Хэрэгжилт | Үнэлгээ |
|--|---|------------------------------|------------------------|--|--|---|---------|
| Зорилт 1. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛНЭ. | | | | | | | |
| 1.1 | Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Цогтцэций чиглэлийн төмөр замын тээвэрлэлтийг нэмэгдүүлэх | - Ачааны хэмжээ, сая.тонн | 1.06 сая.тн | 2024 онд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 1.752 сая.тонн, Тавантолгой-Цогтцэций чиглэлд 2.405 сая.тонн, нийт 4.157 сая.тонн ачааг тээвэрлэсэн. | I улирал: нийт 2.05 сая.тн ачаа II улирал: нийт 4.74 сая.тн ачаа III улирал: нийт 7.26 сая.тн ачаа IV улирал: Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Цогтцэций чиглэлд нийт 10.64 сая.тн /өссөн дүнгээр/ | "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн тээврийн төлөвлөгөөг "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд шууд нэмж оруулахдаа "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Тавантолгой-Цогтцэций чиглэлд тээвэрлэх 3.05 сая тонн ачааны хэмжээг хасалгүйгээр оруулсан нь Тавантолгой – Зүүнбаян чиглэлд тээвэрлэх ачааны хэмжээнд давхардан орж 10.64 сая.тн ачаа тээвэрлэхээр батлагдсан бөгөөд төлөвлөгөөнөөс давхардан оруулсан 3.05 сая.тн ачааг хасаж тооцвол, төлөвлөгөө 7.59 сая.тн болж байна. "Монголын төмөр зам" ТӨХК нь 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Цогтцэций-Зүүнбаян, Тавантолгой-Ханги (Зүүнбаян-Цогтцэций-Тавантолгой) чиглэлд 8.019 сая.тн ачаа тээвэрлэсэн бөгөөд / чингэлэгийн жинг тооцохгүй цэвэр ачааны хэмжээ нь 7.040 сая.тн/ төлөвлөгөөний биелэлт нь 105,6% биелээд байна/ Монгол Улсын Засгийн газар, “Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо”-ны 2025 оны 01 дүгээр сарын хамтарсан хурлын шийдвэр, “Тавантолгой түлш” ХХК-аас ирүүлсэн 2025 он 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01/16 дугаартай албан бичгийн дагуу 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл мидлингийн тээвэр түр хугацаагаар зогссон. Мөн тус албан бичгийн хавсралтаар 2025 оны 06 сараас – 2026 оны 05 сар хүртэлх тээвэрлэлтийн урьдчилсан төлөвлөгөөг ирүүлсэн, 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 04/864 дугаартай албан бичгээр 130,000 тонн мидлинг татан авах тухай мэдэгдсэн бөгөөд оны эхнээс 1,813 вагон 120,316.85 тээвэрлээд байна.. | 70% |

| | | | | | | | |
|-----|--|--|---|---|-------------|--|-------------|
| | | | | | | <i>Тайлбар; Гүйцэтгэлийн төлөвлөгөөний тодотгол буюу нэмэгдсэн ажил үүрэгүүд 2025 оны 11 дүгээр сарын 11-ны өдөр батлагдсан хэдий ч гүйцэтгэл 70%-иас дээш үзүүлэлттэй байгааг тэмдэглэн хэлэх нь зүйтэй.</i> | |
| 1.2 | Төмөртэй-Хандгайт чиглэлийн төмөр замаар тээвэрлэх ачааны хэмжээг нэмэгдүүлэх | - Тээвэрлэсэн ачааны хэмжээ мян.тн | 306.7 мян.тн | I улирал: 98.6 мян.тн ачаа II улирал: 198.35 мян.тн ачаа III улирал: 299.18 мян.тн ачаа IV улирал: Өссөн дүнгээр 500мян.тн ачаа | I-IV улирал | “Монголын төмөр зам” ТӨХК нь 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар нийт 17,324 вагон, 957 мян.тн ачааг Төмөртэй-Хандгайт чиглэлд төмөр замаар тээвэрлэсэн. Тээврийн төлөвлөгөөний биелэлт 191.4% байна. | 100% |
| 1.3 | Тээвэр зуучлалаар ачаа тээвэрлэх | Ачааны хэмжээ, тонн | Тээвэр зуучлалаар 2024 онд өдрийн байдлаар 101,392 тн ачаа тээвэрлэсэн. | Тээвэр зуучлалаар: I улиралд: 10.000 тн II улиралд: 20.000 тн III улиралд: 40.000 тн IV улиралд: 60.000 тн | I-IV улирал | “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн тээвэр зуучлалаар 377 вагон, 25.5 мян.тн ачаа, 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрөөс -11 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд 988 вагон, 67.3 мян.тн ачаа, нийт 1365 вагон, 92.8 мян.тн ачааг Тавантолгой-Зүүнбаян чиглэлд тээвэр зуучлалын үйлчилгээ үзүүлэн тээвэрлэсэн. Төлөвлөгөөний биелэлт 154.6% байна. | 100% |
| 1.4 | Тавантолгой түлш ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний түүхий эд (мидлинг)-ийг төлөвлөсөн хэмжээнд тээвэрлэх. | - Төлөвлөгөөний гүйцэтгэл, хувь | 2024 онд 517 мянган тн тээвэрлэсэн буюу 95,8 хувийн гүйцэтгэлтэй | I улирал: 145.0 мян.тн ачаа II улирал: 293.0 мян.тн ачаа III улирал: 439.0 мян.тн ачаа IV улирал: Өссөн дүнгээр 587.0 мян.тн ачаа | I-IV улирал | “Монголын төмөр зам” ТӨХК нь “Тавантолгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний түүхий эд (мидлинг)-ийг 2025 оны 1-р улиралд 0.037 сая тонн, 2-р улиралд 0 тонн, 3-р улиралд буюу 2025.09.14-ний өдрийн байдлаар 0 тонн ачааг Тавантолгой- Зүүнбаян төмөр замаар тээвэрлээд байна. <u>Төлөвлөгөө тасалдсан шалтгаан:</u> Монгол Улсын Засгийн газар, “Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо”-ны 2025 оны 01 дүгээр сарын хамтарсан хурлын шийдвэр, “Тавантолгой түлш” ХХК-иас ирүүлсэн 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01/16, 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 01/223 дугаартай албан бичгүүдээр мидлинг тээвэрлэлтийг зогсоосон. 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс ачаа хүлээн авах тухай албан бичгээр | Ү/Б |

| | | | | | | | |
|-----|---|------------------------------|--------------------------------------|--|------------------|---|------|
| | | | | | | <p>мэдэгдсэн боловч өнөөдрийг хүртэл хугацаанд тээвэрлэлт хийлгээгүй.</p> <p><i>Тайлбар Тайлбар; Уг арга хэмжээг дээд байгууллагын шийдвэрээр зогсоосон тул үнэлэх боломжгүй гэж үзсэн.</i></p> <p><i>Жич: Нотлох баримтыг хавсаргаав..</i></p> | |
| 1.5 | Зүтгүүрүүдийг их засвараас хүлээн авч, тээврийн үйл ажиллагаанд явуулах | Хүлээн авсан зүтгүүрийн тоо | 2 зүтгүүр их засвараас хүлээн авсан. | <p>I улирал: CKD4b серийн 2 зүтгүүр, DF7g3 зүтгүүрүүдийг хүлээн авсан байна.</p> <p>II улирал: ES44Ac1 болон 2ТЭ116 загварын 2 зүтгүүрийг хүлээн авсан байна.</p> | I, II улирал | <p><i>DF7g загварын 2401 дугаарын илчит тэргийг 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр гүйцэтгэгч компаниас акт үйлдэн хүлээн авсан.</i></p> <p>Компанийн эзэмшлийн CKD4b загварын 2301, 2303 дугаарын илчит тэрэгнүүдийн их засварын гүйцэтгэл 90 хувьтай бөгөөд 2025 оны III улирлын байдлаар ES44Ac1 загварын 2101 дугаарын илчит тэргийг их засвараас 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр, 2ТЭ116 загварын илчит тэрэгний А секцийн модернизацийн ажлыг гүйцэтгэж 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдөр хүлээн авсан.</p> | 100% |
| 1.6 | Ачааны 332 вагоны “Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектын гэрчилгээ”-г сунгуулах материалыг Зам, тээврийн яаманд хүргүүлэх | Сунгуулсан гэрчилгээн ий тоо | 332 | <p>I улирал: Ачааны 57 вагоны гэрчилгээг сунгуулсан байна.</p> <p>II улирал: Ачааны 30 вагоны гэрчилгээг сунгуулсан байна.</p> <p>III улирал: Ачааны 245 вагоны гэрчилгээг сунгуулсан байна.</p> | I-III улирал | <p>Монгол Улсын Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Төмөр замын газарт 2025 оны 07 дугаар сарын 24-ний өдөр 01/1295 тоот албан бичгээр компанийн эзэмшлийн 57 хоппер, 30 хагас вагоны “Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектын гэрчилгээ”-г сунгуулах хүсэлт, хавсралт материал болон өмчлөгчийн мэдээлэл, чанарын гэрчилгээ, техникийн паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээ, дугаарлалт олгосон тухай албан бичиг, төлөвлөгөөт засварт оруулсан тухай тайлангийн хамт хүргүүлсэн.</p> <p>Ачааны 245 вагоны гэрчилгээг сунгуулах ажил нь 2025 оны 10 дугаар сарын 31-нд дуусах тул сунгах бэлтгэл ажлыг ханган 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр Монгол Улсын Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Төмөр замын газар руу хүсэлт, хавсралт материалыг хүргүүлсэн ба нийт 332 гэрчилгээг сунгуулсан.</p> | 100% |
| 1.7 | Ckd4b, DF7g, Evolution болон 2ТЭ-116М серийн зүтгүүрүүдийн “Төмөр замын | Авсан гэрчилгээн ий тоо | - | <p>I улирал: 4 зүтгүүрийн “Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай</p> | I, III-IV улирал | <p>Компанийн эзэмшлийн 7 илчит тэргийг төлөвлөгөөт их засварт 2 багц болгон засварлуулах ажил хийгдэж байна. CKD4b-2301,2303,2304,2305 зүтгүүрүүдийг БНХАУ-ын Далиан Ван Фун ХХК-д их засвар хийлгэж байгаа бөгөөд</p> | 100% |

| | | | | | | | |
|-----|---|---|---|---|--------------|--|------|
| | тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектын гэрчилгээ"-г Зам тээврийн яамнаас авахаар материалыг хүргүүлэх | | | холбоотой объектын гэрчилгээ"-г авсан байна. III улирал: 2 зүтгүүрийн "Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектын гэрчилгээ"-г авсан байна. IV улирал: 2 зүтгүүрийн "Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектын гэрчилгээ"-г авсан байна. | | CKD4b-2304,2305 зүтгүүрүүдийг 2024.12.02-ны өдөр Монгол улсад хүлээн авч ашиглалтад оруулсан. DF7g-2401, Evolution-2101 зүтгүүрүүдийн бичиг баримтыг 2025 оны 08 дугаар сарын 10-ны өдөр 2ТЭ116-2001 зүтгүүрийг Зам, тээврийн яамны комиссын бүрэлдэхүүнтэй шалгахад 3 зүтгүүрийн бичиг баримтыг албан ёсоор хүлээн авсан. 5 илчит тэрэгний материалуудыг бүрдүүлж "Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектын гэрчилгээ" авах хүсэлтийг Зам, тээврийн яамны харьяа "Төмөр замын газар"-т 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр цахимаар хүргүүлсэн, нийт 8 объектын гэрчилгээг авсан. | |
| 1.8 | Зам тээврийн яамнаас олгодог "Зүтгүүр үзлэгийн техникийн үйлчилгээ хийх тусгай зөвшөөрөл"-ийн хугацааг сунгуулах, урсгал засвар хийх тусгай зөвшөөрөл авах, зүтгүүрийн эд анги засварлах тусгай зөвшөөрлийг авахаар хүсэлт гаргах | Тусгай зөвшөөрлийг сунгуулсан, авсан эсэх | 1 | I улирал: "Зүтгүүрийн урсгал засвар хийх тусгай зөвшөөрөл"-ийг сунгуулсан байна. II улирал: "Зүтгүүрийн урсгал засвар хийх тусгай зөвшөөрөл"-ийг шинээр авсан байна. III улирал: "Зүтгүүр түүний эд ангийг засварлах тусгай | I-III улирал | Монгол Улсын Засгийн газрын 103 дугаар тогтоолын дагуу Төрийн өмчит аж ахуйн нэгжийн зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх, төмөр замын тээврийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах зорилгоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах арга хэмжээ авах болсонтой холбогдуулан "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Зүтгүүрийн депо нь Зам, тээврийн яамнаас олгодог "Зүтгүүр үзлэгийн техникийн үйлчилгээ хийх тусгай зөвшөөрөл" болон "Урсгал засвар хийх тусгай зөвшөөрөл"-ийг авсан бөгөөд тухайн тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаагүй байна. Энэ тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. | 100% |

| | | | | | | | |
|------|--|----------------------------|---|--|-----------|---|------|
| | | | | зөвшөөрөл"-ийг шинээр авсан байна | | | |
| 1.9 | Хөдлөх бүрэлдэхүүнийг өвлийн тээвэрт бэлтгэх. | - Тээвэрт бэлтгэсэн тоо | 2024 онд хөдлөх бүрэлдэхүүнийг өвлийн тээвэрт бэлтгэсэн. | IV улирал: Хөдлөх бүрэлдэхүүнийг өвлийн тээвэрт бэлтгэнэ. | IV улирал | Компанийн эзэмшлийн 6 илчит тэрэг болон "Тавантолгой төмөр зам" ХХК-аас хөрөнгө түрээслэх гэрээний дагуу ашиглаж буй 16 илчит тэргэнд 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хооронд өвлийн тээвэрт бэлтгэх үзлэг засварын ажлыг хийж гүйцэтгэсэн. "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/130 дугаартай Ачааны вагоныг өвлийн тээвэрт бэлтгэх техникийн үзлэг, үйлчилгээ хийх журмын дагуу ачааны 1143 вагонд хийж гүйцэтгэхээс 1011 вагонд хийж гүйцэтгээд байна. | 100% |
| 1.10 | Вагоны техникийн үзлэг, үйлчилгээ, засвар, Ерөнхий шаардлага"-ыг мөрдлөг болгож өөрийн эзэмшлийн 100 ширхэг хагас вагоныг дунд засвараар засварлах сэлбэг, хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх. | - Ажлын гүйцэтгэл | Компанийн 2025 оны үйл ажиллагааны төсөвт 100 хагас вагоны дунд засварт шаардлагатай сэлбэг, хэрэгсэл, материалын зардлын саналыг хүргүүлсэн. Ачааны вагоны дунд засварын технологийн горим болон засварын үнэлгээг тус тус батлуулсан. | I улирал: 100 хагас вагоны дунд засварт шаардлагатай сэлбэг материалыг бүрдүүлсэн байна. | I улирал | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 103 дугаар тогтоолын дагуу "Тавантолгой төмөр зам" ХХК-аас хөрөнгө түрээслэх гэрээний дагуу "Тавантолгой төмөр зам" ХХК, "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/97, А/182 дугаар хамтарсан тушаалын дагуу Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын цогцолбор төслийн хүрээнд нийлүүлэгдсэн 75 нэр төрлийн вагоны сэлбэг, эд ангийг 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдөр хүлээн авч нөөцийг бүрдүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|------|---|--------------------------|---|---|---------------|--|------|
| 1.11 | Вагоны техникийн үзлэг, үйлчилгээ, засвар. Ерөнхий шаардлага"-ыг мөрдлөг болгож өөрийн эзэмшлийн 100 ширхэг хагас вагоныг дунд засвараар засварлах ажлыг гүйцэтгэх. | - Ажлын гүйцэтгэл | Компанийн 2025 оны үйл ажиллагааны төсөвт 100 хагас вагоны дунд засварт шаардлагатай сэлбэг, хэрэгсэл, материалын зардлын саналыг хүргүүлсэн. Ачааны вагоны дунд засварын технологийн горим болон засварын үнэлгээг тус тус батлуулсан. | II улирал: 50 хагас вагоныг дунд засвараар засварлаж Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан байна. III улирал: 50 хагас вагоныг дунд засвараар засварлаж Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан байна. | II-III улирал | Хуваарийн дагуу эхний 50 ачааны хагас вагоны дунд засварт шаардлагатай сэлбэг хэрэгсэл, материалын нөөцийг бүрдүүлж төлөвлөгөөт дунд засварын ажлыг 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрөөс 2025 оны 09 дүгээр 03-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн. Үлдсэн 50 ачааны хагас вагоны дунд засварын ажлыг 2025 оны 09 дүгээр 10-ны өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн хооронд хийж тээвэрт хэвийн ашиглаж байна. | 100% |
| 1.12 | Гол замын 343-344-р км, 354-355-р км, 376-р км-т 2250 м.куб балласт дүүргэх ажлыг тендерийн сонгон шалгаруулалтын үндсэн дээр гүйцэтгэх | Балласт буусан /5 км/ | 1 км буюу 270 м.куб балласт дүүргэсэн. | I улирал Тендерт шаардагдах техникийн тодорхойлолтыг гарган өгнө. II улирал Тендер зарлуулж нийлүүлэгч компанийг шалгаруулна. III – IV улирал Балластыг буулгаж дэрийн хайрцгийг 5 км балласт | I-IV улирал | Балласт дүүргэх ажлын тендерт шаардагдах техникийн тодорхойлолтыг шинэчлэн 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр Ерөнхий инженерээр батлуулж, Худалдан авалтын хэлтэст хүргүүлсэн. Тендерийг 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр зарласан бөгөөд оролцогч тендер ирүүлээгүй шалтгаанаар амжилтгүй болсон бөгөөд шалтгаан нөхцөлийг судалж дахин 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр тендерийг дахин зарласан. 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдөр нээгдэж "Боврой" ХХК шалгарч 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр ХХАГ 2025/36 дугаартай гэрээг байгуулсан. Гэрээний дагуу 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн ЗААХ-ийн №6 дугаартай цахилгааны дагуу Цогтцэций-Хонгортолгой хоорондын замд балластыг буулгаж дүүргэлтийг хийсэн. | 100% |

| | | | | | | | |
|------|---|-------------------------------|-------------------------------|---|---------------|---|------|
| | | | | дүүргэсэн байна. /100%/ | | | |
| 1.13 | Гол замын 283 – 413-р км -т буюу хориг хашааны уртыг 260 км-ээр нэмэгдүүлж барих /2 талдаа/ | Баригдсан хориг хашаа /260 км | 194.8 км хориг хашаа барьсан. | I улирал Тендер зохион байгуулахад шаардагдах техникийн тодорхойлолтыг гарган баталж, Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлнэ. II улирал Тендер зарлуулан, сонгон шалгарсан оролцогчтой гэрээ байгуулна. III – IV улирал Гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж гэрээг дүгнэн, холбогдох санхүүжилтийг олгоно. 260 км хориг хашааг барих ажлыг бүрэн гүйцэтгүүлж, хүлээн авсан байна. /100%/ | I – IV улирал | Гол замын 283-413 дугаар километрт хориг хашааг барихаар 5 багц болгон тендер зарлахаар төлөвлөсөн. I багцын техникийн тодорхойлолтыг 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр батлуулж тендер зарласан. Сонгон шалгаруулалтаар “Баянхайрхан баянбулаг” ХХК гүйцэтгэгчээр шалгарч 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр гэрээ байгуулж, 283-р км-с 297-р -км-т 22 км хориг хашааг барих ажлыг 2025 оны 07 дугаар сард хийж гүйцэтгэсэн. II, III, IV, V багцын техникийн тодорхойлолтыг 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр шинэчлэн батлуулж тендерийг зарлуулж 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдөр компаниудыг сонгон шалгаруулсан. Багц II – “Ганцацал” ХХК шалгарч, АГГ-2025/144 дугаартай гэрээг, Багц III – “Баян төхмийн хурд” ХХК шалгарч АГГ-2025/146 дугаартай гэрээг, Багц IV – “Баянхайрхан Баянбулаг” ХХК шалгарч АГГ-2025/145 дугаартай гэрээг, Багц V – “Баянхайрхан Баянбулаг” ХХК шалгарч АГГ-2025/143 дугаартай гэрээг тус тус байгуулсан. 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар: Багц II ажил /222км пк4-235км пк4, 298км пк1-314км пк4 - нийт 59км/ нь 100%-ийн гүйцэтгэлтэй; Багц III ажил /314км пк5-328пк4, 328км пк9-344км пк3 - нийт 59км/ нь 100%-ийн гүйцэтгэлтэй; Багц IV ажил /344км пк4-352км пк2, 352км пк7-356км пк1, 360км пк8-371км пк2, 371км пк7-379км пк7 -нийт 60км/ нь 100%-ийн гүйцэтгэлтэй Багц V ажил /379км пк8-409км пк7 - нийт 60км/ нь 100%-ийн гүйцэтгэлтэйгээр ажлыг бүрэн гүйцэтгүүлж, хүлээн авсан. | 100% |
| 1.14 | 35/10 кВ Шинэ өртөө дэд станцаас 35/0.4 кВ | Реклоузер суурилуулс | - | I улирал Тендерт шаардагдах | I-IV улирал | 2 иж бүрэн реклоузерын ажлын зураг төсөв хийх ажлын тендерт “Эрчим шугам проект” ХХК шалгаран ажлын зураг төсвийг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. 2 иж бүрэн | 100% |

| | | | | | | | |
|------|--|----------------------|--|---|-------------|---|-------------|
| | Хонгор толгой дэд станц хүртэлх ЦДАШ эхэнд 2 иж бүрэн реклоузер суурилуулах | ан эсэх /2 иж бүрэн/ | | техникийн тодорхойлолтыг гарган өгнө. II улирал Тендер зарлуулж нийлүүлэгч компанийг шалгаруулах, худалдан авалтыг хийнэ. III – IV улирал 2 иж бүрэн реклоузерийг суурилуулна. /100%/ | | реклоузер суурилуулах ажлыг батлагдсан төсвийн дагуу холбогдох мөнгөн дүнгээр 2025 оны төсвийн тодотголд оруулсан. | |
| 1.15 | Төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт, засвар үйлчилгээ, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалт, ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах. | - Ажлын явц | Төмөр замын тээврийн тухай хууль болон бусад тушаал шийдвэрийг мөрдөж ажилласан. | I улирал: Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулж ажиллах төлөвлөгөөг батлуулсан байна. I-IV улирал: Төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт, засвар үйлчилгээ, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалт, ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаанд гарч буй үл тохирлыг давтан гаргуулахгүй | I-IV улирал | Суурь бүтцийн хэмжээнд нормативт үзлэг шалгалтыг сар бүрийн 05-ний өдрийн дотор өртөө, зөрлөгийн дарга, Дохиолол холбооны ангийн дарга, ахлах инженер, Замын ангийн дарга, ахлах инженер нарын бүрэлдэхүүнтэй комиссоор нийт 3 өртөө, 13 зөрлөгийн давхардсан тоогоор 3941 суман шилжүүлэгт үзлэг шалгалтыг зохион байгуулж 728 нэгж үл тохиролыг /зам, суман шилжүүлгийн гэмтэл/ илрүүлж засварласан | 100% |

| | | | | | | | |
|------|---|-----------------|---|---|-----------|---|------|
| | | | | байх дээр хяналт тавьж, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулж ажилласан байна. | | | |
| 1.16 | Замын байгууламжуудын найдвартай, бүрэн бүтэн байдлыг хангах. | Ажлын гүйцэтгэл | Төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс давхардсан тоогоор зам хоорондын 94477 пог/м элс цэвэрлэх ажил хийсэн. | I улирал: Замын байгууламжийн бүрэн бүтэн байдал, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө батлуулна. IV улирал: Галт тэрэгний хөдөлгөөний тасралтгүй, аюулгүй байдлыг хангах, төмөр замын байгууламжийн хэвийн ашиглалтыг хангах зорилгоор өдөр тутмын засвар үйлчилгээ, паспортын үзлэг, шалгалтыг тогтмол зохион байгуулж, | IV улирал | Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр намрын паспортын үзлэгийг Замын ангийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 09/02 дугаартай тушаалын дагуу 2025 оны 09 дүгээр сарын 07-ны өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдрийг дуустал зохион байгуулсан. Үзлэгийн мөрөөр 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн “Хойшлуулшгүй ажлын төлөвлөгөө”-г 48 заалттай гаргасан. Төлөвлөгөөний биелэлт 2025 оны 12-р сарын 01-ний өдрийн байдлаар 100%-тай хэрэгжсэн байна | 100% |

| | | | | | | | |
|------|--|----------------------------------|---|---|-----------|---|------|
| | | | | гүйцэтгэсэн байна. | | | |
| 1.17 | Гол зам, хүлээн авах явуулах зам сум, салбар зам, гарам, хориг хашаа, гүүр хоолойнуудын урсгал засварыг хийх, нөөц бүрдүүлэх, суваг шуудууны элсийг цэвэрлэнэ. | Илэрсэн дутагдлыг арилгасан эсэх | 2024 оны 11 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар: Батлагдсан төлөвлөгөө, графикийн дагуу суман шилжүүлэгт 3671 ш, гүүр хоолойд 2956 ш, гарамд 121 ш үзлэг шалгалтыг хийсэн биелэлт 100 хувьтай байна. Хориг хашаанд нийт 112179.8 км-т үзлэг хийж биелэлт 100 хувийн гүйцэтгэлтэй байна. Шуудууны элс 16160м цэвэрлэж, 18890 м3 хаягдал элс зөөвөрлөсөн | I улирал: Урсгал засвар хийх, нөөц бүрдүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулна. IV улирал: Төлөвлөгөөт болон ажлын графикийн дагуу төмөр замын дээд, доод бүтцийн барилга байгууламжид тогтмол үзлэг, шалгалт хийж, гүйцэтгэлийн биелэлт бүрэн хангасан байна | IV улирал | 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар графикийн дагуу замыг явганаар 7711 км замыг шалгасан, суман шилжүүлэгт 3941 удаад үзлэг хийсэн, гүүр хоолойд 2980 удаад үзлэг шалгалтыг хийсэн, гармын техникийн байдалд 126 удаа үзлэг шалгалт хийсэн, хориг хашаанд 114423 км-т үзлэг шалгалт хийж 100%-ийн биелэлттэй ажиллаж байна. Төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс давхардсан тоогоор зам хоорондын 42645 пог/м-т шуудууны элс болон замын элс цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. | 100% |
| 1.18 | Төмөр замын бүх өртөө, зөрлөгийн дохиолол | - Хөдөлгөөн ий аюулгүй | Батлагдсан жилийн ажлын | IV улирал: Долоо хоногийн болон жилийн | IV улирал | Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын өртөө, зөрлөгүүдийн дохиолол | 100% |

| | | | | | | | |
|------|---|-----------------------|---|--|-------------|--|------|
| | холбооны байгууламж, Тетра тоон радио систем, галт тэрэгний хажуугийн илрүүлэх системүүдийн хээрийн болон удирдлагын байранд байрлах тоног төхөөрөмжүүдэд техникийн засвар, үйлчилгээг хийх. | байдлыг хангасан эсэх | зурмагийн дагуу шалгаж, технологи картын дагуу техникийн үйлчилгээг 100 хувь хийж ажиллах | зурмагт ажлыг тухай бүр хийж галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй, хурдан, шуурхай байдлыг хангуулсан байна | | холбооны байгууламж, Тетра тоон радио систем, галт тэрэгний хажуугийн илрүүлэх систем, удирдлагын байранд байрлах тоног төхөөрөмжүүдэд техникийн засвар үйлчилгээ болон 4-н долоо хоног, сар, улирал, жилд хийгдэх технологийн зурмагт ажлыг баталсан графикайн дагуу хийж гүйцэтгэж, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажилласан. | |
| 1.19 | Эзэмшлийн шугам сүлжээ, дэд станцын тоноглолуудад шаардлагатай засвар үйлчилгээ хийх, нэгдсэн шугам сүлжээний энергийн алдагдлыг тооцож төлөвлөгөөт урьдчилсан сэргийлэх үзлэгийн график батлуулж мөрдөж ажиллах. | - Ажлын явц | Эрчим хүчний чанарын үндсэн үзүүлэлт, шугам сүлжээ, дэд станцын тоноглолын хэвийн ажиллагааг бүрэн хангаж ажиллах | I улирал: Нэгдсэн төлөвлөгөөг батлуулна. IV улирал: Шугам сүлжээний энергийн алдагдлыг бууруулах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэн 2024 онд 12.1% байсан эрчмийн алдагдлыг 6.8% хүртэл бууруулсан байна. | I-IV улирал | Төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх үзлэгийн дагуу - Агаарын шугам, кабель шугамд - 68 удаа - Байнгын жижүүргүй дэд станц, хуваарилах байгууламжуудын тоноглолд – 312 удаа - Байнгын жижүүртэй дэд станц, хуваарилах байгууламжийн тоноглолд – 1095 удаа - Зам паркийн гэрэлтүүлэгт – 120 удаа - Дизель генераторт – 120 удаа хийсэн. Цахилгаан хэрэглэгч, шугам тоноглолуудыг оновчтой горимд шилжүүлэн ажиллуулснаар (зам паркийн цагийн механизмтай гэрэлтүүлгийн ажиллах цагийг өвөл, зуны горимд тохируулан ажиллуулах, ачааллын нягтрал багатай зуны саруудад дэд станцын зэрэгцээ ажиллаж буй хоёр трансформаторуудыг нэг нэгээр нь ээлжлэн ажиллуулах гэх мэт) дээрх зөрчлүүдийг тухай бүр арилгах арга хэмжээ авч эрчим хүчний үр ашиггүй хэрэглээ, хэвийн бус горим ажиллагаанаас үүсэх алдагдлыг бууруулж эрчим хүчний хэмнэлтийг бий болгон техникийн, техникийн бус эрчмийн алдагдал өмнөх оныхоос 5.3%-ар бууруулж 6,8% болгосон. | 100% |
| 1.20 | Ачаа тээвэр, хөдөлгөөн зохион байгуулалтын чиглэлээр | Ажлын гүйцэтгэл, хувь | шинээр | III улирал: Төмөр замын ачаа тээвэр, галт тэрэгний | I-IV улирал | 1. Тавантолгой-Гацуунсухайт-Тавантолгой чиглэлд Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор Trains программыг 100 хувь ашиглаж байна. | 90% |

| | | | | | | | |
|------|---|-----------------------|--------|--|-------------|--|-------------|
| | программ хангамжийг бүрэн нэвтрүүлэх. | | | хөдөлгөөн зохион байгуулалтын программ хангамжийн үйл ажиллагааг зүгшрүүлсэн байна. IV улирал: Төмөр замын ачаа тээвэр, захиалга, хөдөлгөөн зохион байгуулалтын программ хангамжийг үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн байна. Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон бусад төмөр зам, харилцагч байгууллагуудтай программ хангамжийн хүрээнд мэдээллийг харилцан солилцож эхэлсэн байна. | | 2. Тавантолгой-Гашуунсухайт-Тавантолгой чиглэлд Ачаа тээврийн анхан шатны бичиг баримтыг бүртгэх, тээврийн бичиг баримт бүрдүүлж төлбөр тооцоог тарифын дагуу тооцох, харилцагч байгууллагуудтай мэдээлэл солилцох зорилгоор Freights программыг туршилтаар ашиглаж сайжруулалт хийгдэж байна. 3. Тавантолгой-Гашуунсухайт-Тавантолгой чиглэлд Төмөр замын тээврийн тайлан мэдээг үнэн зөв бодитой шуурхай гаргах зорилгоор Reports программ 85-аас дээш хувийн гүйцэтгэлтэй байна. | |
| 1.21 | ТЗХАБ-ын гишүүн орнуудын 3 дугаар хэсгийн төмөр замуудаар 2025 онд олон улсын | Ажлын гүйцэтгэл, хувь | шинээр | I улирал: Хуралдаан зохион байгуулах бэлтгэл хангасан байна. | I-II улирал | ТЗХАБ-ын гишүүн орнуудын ачааны хэмжээ тохиролцох зөвлөгөөн Монгол Улсад 2025 оны 03 дугаар сарын 10-14-ний өдрүүдэд болж өндөрлөв. Тус хуралд “Монголын төмөр зам” ТӨХК ажиглагчийн байр сууринаас оролцсон. Уг хурлыг зохион байгуулах ажлын хэсэгт ГХОНХХ-ийн | 100% |

| | | | | | | | |
|------|--|----------------------------|--------|---|---------------|--|------|
| | харилцаанд ачаа тээвэрлэлтийн хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг зөвшилцөх хуралдааныг Улаанбаатар хотноо зохион байгуулахад хамтран оролцох. | | | II улирал: Хуралдаанд оролцсон байна. | | дарга М.Энх-Амгалан, Ачаа тээврийн хэлтсийн дарга О.Амарсанаа, Гадаад харилцааны мэргэжилтэн С.Марал нар оролцон хамтран ажилласан. | |
| 1.22 | Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төмөр замуудын төлөөлөгчдийн зөвлөгөөн болон Монгол-Орос, Монгол-Хятадын хилийн төмөр замын комиссын зөвлөгөөнийг Улаанбаатар хотноо зохион байгуулахад хамтран оролцох. | Ажлын гүйцэтгэл, хувь | шинээр | III улирал: Хуралдаан зохион байгуулах бэлтгэл хангах ажилд оролцсон байна. IV улирал: Хуралдаанд оролцсон байна. | III-IV улирал | 2025 оны 08 дугаар сарын 25-29-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хамтарсан төмөр замын төлөөлөгчдийн зөвлөгөөн зохион байгуулагдсан. Тус зөвлөгөөнд “Монголын төмөр зам” ТӨХК-аас Ерөнхий инженер Д.Батнасан, Гадаад харилцаа, мэдээлэл технологийн газрын ахлах мэргэжилтэн Э.Дэлгэрмөрөн, Бээжинд суугаа төлөөлөгч Д.Энхбаяр нар оролцсон. Зөвлөгөөний үеэр Ерөнхий инженер Д.Батнасан “Шивээхүрэн–Сэхээ” чиглэлийн хил холболтын төмөр замын төслийн талаар танилцуулга хийж, оролцогчдод мэдээлэл өгч, хэлэлцүүлэг хийгдсэн. Мөн Хөх Хотын төмөр замын Гадаад эдийн засаг, технологийн хамтын ажиллагааны групп ХХК-ны Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Жан Жунпин-тэй уулзалт хийж, хамтын ажиллагааны талаар санал солилцсон. | 100% |
| 1.23 | Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллага (ТЗХАБ)-ын Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээр (ОУАХХ)-ийн нөхцөлөөр олон улсын | - Ажлын гүйцэтгэл, хувь | шинээр | I-II улирал: ОУАХХ-ийн нөхцөлөөр олон улсын тээвэрлэлтийг зохион байгуулах бэлтгэл хангах III улирал: ОУАХХ-ийн нөхцөлөөр олон улсын тээвэрлэлтийн | I-IV улирал | ТЗХАБ-ын гишүүн орнуудын ачилтын өртөөдийн жагсаалтад Монгол улсын төмөр замын сүлжээн дэх олон улсын ачилт буулгалтад нээлттэй өртөөдийн жагсаалт 2025 оны 10 сард шинэчлэгдэн гарч 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхлэхээр болсон. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Цогтцэций, Борхошуу, Тавантолгой, Гашуунсухайт өртөөд олон улсын тээвэрт ачаа хүлээн авах, вагон илгээлт, дунд болон их даацын чингэлэг илгээлтэд нээлттэй болсон. Ачаа хүлээн авагч нар импортоор оруулж ирж байгаа ачаануудаа Цогтцэций, Тавантолгой, Гашуунсухайт, Борхошуу өртөөдөд шууд хүргэн гаалийн бүрдүүлэлтийг хийх боломжтой болсон. | 100% |

| | | | | | | | |
|------|--|-------------------------------|--|---|-------------|---|-------------|
| | тээвэрлэлтийг зохион байгуулах | | | туршилтыг зохион байгуулах IV улирал: ОУАХХ-ийн нөхцөлөөр олон улсын тээвэрлэлтийг жигдрүүлэх | | 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн ОУАХХ-ийн нөхцөлөөр тээврийг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах зорилгоор УБТЗ-МТЗ хамтарсан ажлын хэсгийг /албан бичгээр зөвшилцөн/ гарган ажиллахаар шийдвэрлэсэн. | |
| 1.24 | Төмөр замын тээврийн технологийн бичиг баримтуудад өөрчлөлт оруулж батлуулж мөрдөх | Батлуулсан баримт бичгийн тоо | 2024 онд тээврийн үйл ажиллагаатай холбоотой 3 журам, 14 заавар, 1 дэглэм, 1 гарын авлага, 14 технологийн бичиг баримтыг батлуулан мөрдөж ажиллаж байна. | I-IV улирал: Тавантолгой, Гашуунсухайт өртөө, зөрлөгүүдийн ТЗА, ТТӨ, ГСӨ-ийн технологийн горим, сэлгээний зааврууд болон бусад 12 бичиг баримтад хуульд орсон өөрчлөлтийн дагуу нэмэлт, өөрчлөлтийг үе шаттай хийж батлуулна. | I-IV улирал | Тавантолгой, Гашуунсухайт, Цогтцэций хэсэглэлийн харьяа өртөө, зөрлөгүүдийн нийт 5 технологийн горим, 15 сэлгээний заавар болон бусад 22 бичиг баримтад нэмэлт өөрчлөлт оруулж, батлуулан, мөрдөн ажиллаж байна. | 100% |
| 1.25 | Эргэдэг автоугсраа бүхий ачааны нэг хагас вагон угсрах | - Гүйцэтгэлийн хувь | Гүйцэтгэх захирлын 2024 оны А/139 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдана, төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөний дагуу ажиллан, нэг ачааны хагас вагон угсрахад | I-II улирал: Эргэдэг автоугсраа бүхий ачааны нэг хагас вагон угсарч, холбогдох тусгай зөвшөөрлийг авч, төмөр замын тээвэрт оролцуулна. | I-II улирал | "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Гашуунсухайт засварын төвд угсарсан эргэдэг автоугсраа бүхий ачааны хагас вагоныг "Тавантолгой төмөр зам" ХХК, "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/97, А/182 дугаар хамтарсан тушаалын дагуу 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдөр бүрэн угсруулан хүлээн авсан. | 100% |

| | | | | | | | |
|------|--|-------------------------------|--|---|-------------|---|------|
| | | | шаардлагатай сэлбэг, хэрэгслийн жагсаалтыг гаргасан. | | | | |
| 1.26 | Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэх | - Хөдлөх бүрэлдэхүүний тоо | Нийт 829 ш хөдлөх бүрэлдэхүүнтэй. Үүнээс зүтгүүр 16 ш, Ачааны вагон 810 ш, Зорчигчийн вагон 1ш, тусгай зориулалтын 2ш | I-II улирал: Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг 1ш зорчигчийн вагоноор нэмэгдүүлнэ. III-IV улирал: Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг 1ш сэлгээний зүтгүүрээр нэмэгдүүлнэ. | I-IV улирал | 1.Монгол Улсын Засгийн газрын 103-р тогтоолын дагуу Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг “Монголын төмөр зам” ТӨХК-д хөдлөх бүрэлдэхүүнийг түрээсийн гэрээгээр ашиглуулж байна. Үүнээс “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн төслийн хүрээнд хэрэгжих 2GS сэлгээний илчит тэрэг бэлэн болсон “Тавантолгой төмөр зам” ХХК-иас төлбөрийн гүйцэтгэл бүрэн хийгдээгүй хүлээгдэж байна. 2. GSY-300 өөрөө явагч 48 хүний суудалтай вагоныг үй ажиллагаандаа ашиглаж байна. 3. 2025 оны 08 дугаар сард “Монголын төмөр зам” ТӨХК-ийн ECOM-2001 байгаль орчинд ээлтэй хосолсон хөдөлгүүрт илчит тэргийг хүлээн авч сэлгээний хөдөлгөөнд амжилттай ашиглаж байна. | 100% |
| 1.27 | Зүтгүүрийн ашиглалт болон засварын зааврыг орчуулж батлуулах | - Зааврын тоо | SD70Ace/LW серийн зүтгүүрт хийгдэх төлөвлөгөөт засвар үйлчилгээний 5 технологийн горим боловсруулсан, төлөвлөгөөт бус засвар үйлчилгээний 20 технологийн горимыг ЗААХ-ын ИТА нар орчуулж | I-II улирал: SD70Ace/LW серийн зүтгүүрийн ашиглалтын зааврыг орчуулна. III улирал: SD70Ace/LW серийн зүтгүүрийн засварын зааврыг орчуулна. SD70Ace/LW IV улирал: SD70Ace серийн зүтгүүрийн засварын зааврыг батлуулна. | I-IV улирал | 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр SD70Ace/LW серийн зүтгүүрүүдийн ашиглалтын зааврыг орчуулсан. | 100% |

| | | | | | | | |
|------|--|---|--|--|--------------|--|------|
| | | | боловсруула н батлуулсан. | | | | |
| 1.28 | Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд Төмөр замаар зорчигч тээвэрлэх | - Зорчигчийн тоо | 2024 онд Тавантолгой Гашуунсухайт чиглэлд 2914 зорчигч тээвэрлэсэн. | I-IV улирал: Тавантолгой Гашуунсухайт чиглэлд зорчигч тээврийг аюулгүй зохион байгуулна. | I-IV улирал | Тавантолгой-Гашуунсухайт, Цогтцэций-Тавантолгой чиглэлд зорчигч тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулж байна. Үүнээс Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд "Монголын төмөр зам" ТӨХК-ийн ээлжийн ажилтнууд болон "Эрдэнэс Тавантолгой" ХК-тай байгуулсан гэрээний үүргийн дагуу тус байгууллагын ээлжийн ажилтнуудыг тээвэрлэсэн. 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар: 1. "Монголын төмөр зам" ТӨХК дотоод тээвэрлэлт- 56 г/т 1,641 зорчигч 2. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн зорчигч тээвэрлэлт - 23 г/т, 862 зорчигч 3. "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн зорчигч тээвэрлэлт - 44 г/т, 1,236 зорчигч Нийт 3,739 зорчигч тээвэрлэсэн байна. | 100% |
| 1.29 | Төмөр замын зорчигч тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичиг боловсруулах | - Бодлогын баримт бичиг боловсруулах ажлын гүйцэтгэл | Засгийн Гзрын 2021 оны 11 дүээр тэмдэглэл гарсан. | II улирал: Төмөр замын Зорчигч тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн төсөл боловсруулна. III-IV: : Төмөр замын Зорчигч тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн төслийг батлуулна. | II-IV улирал | Төмөр замын тээврийн тухай хууль, "Төмөр замаар зорчигч, тээш, ачаа тээш тээвэрлэх журам"-ыг хэрэгжүүлэх хүрээнд "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын тушаалаар "ГСУ-300К МОТОРТ ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНЭЭР ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТ ХИЙХ ТҮР ЖУРАМ"-ын төслийг боловсруулсан. Суурь бүтцийн газар, Төлөвлөлт статистикийн хэлтэс, Хөдөлгөөн зохион байгуулалтын хэлтэс, Ачаа тээвэр, логистик терминалын хэлтсүүдээс саналыг авсан бөгөөд 2025 оны 12 дугаар сард багтаан батлуулахаар ажиллаж байна. <i>Жич; нотлох баримтыг хавсаргав.</i> | 90% |
| 1.30 | Төмөр замын тээврийн үйл ажиллагаанд хөтөлөгдсөн анхан шатны бичиг баримтуудыг бүртгэх, хянах, боловсруулах, | Ажлын гүйцэтгэлийн хувь, Тайлангийн тоо | 2024.11.17-ны өдрийн байдлаар: Хоногийн мэдээ 323; Сайрын тайлан 11; | I-IV улирал: Хоногийн мэдээг 17:00 цагаар тасалбар болгож, тухайн өдрийн 20:00 цагийн дотор гаргаж хүргүүлнэ. | I-IV улирал | 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Галт тэрэгний хөдөлгөөний хоногийн ажлын төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн нийт 2004 ширхэг зурмагийн PDF хуулбар болон хэвлэмэл материалын архив үүсгэж, цаг тухайд нь тайлан мэдээ, бүртгэл хөтөлөлтийг хийлгэн, хяналт тавьж ажилласан. 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Төмөр замын газраас баталсан галт тэрэгний хөдөлгөөний өвөл, | 100% |

| | | | | | | | |
|------|--|---|---|---|-----------|--|------|
| | тээврийн болон хөдлөх бүрэлдэхүүний тоон ба чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлох, галт тэрэгний хөдөлгөөний зурмаг шинжлэх, шуурхай мэдээ, хатуу тайланг гаргах, тайлагнах | | Улирлын тайлан 3; Хагас жилийн тайлан: 2; Жилийн эцсийн тайлан 1-ийг тус тус хугацаанд нь гаргаж, тайлагнан ажилласан. | Сар, улирал, хагас жил болон жилийн эцсийн байдлаар мэдээ, тайланг дараа сарын 10-ны өдрийн дотор гаргаж, компанийн хэмжээнд болон төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудад тайлагнасан байна. Мэдээ тайланг 100% үнэн бодит гаргана. | | зуны нэгдсэн зурмагийн дагуу нийт 334 хоногийн ажлын төлөвлөгөөт зурмагийг боловсруулж батлуулсан. Цахим мэдээллийн санд Хоногийн ажлын төлөвлөгөөт зурмаг 334 ширхэг, түүний биелэлт 333 ширхэг, Галт тэрэгний хөдөлгөөний гүйцэтгэсэн I болон II тойргийн зурмаг 666 ширхэг, түүний хавсралт буюу галт тэрэгний хөдөлгөөний дэлгэрэнгүй мэдээллийн хуудас 671 ширхэг, нийт 2004 ширхэг материалыг бүртгэж архивлав. “Үзүүлэлт-2025” цахим мэдээллийн санд 2025 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 6661 галт тэрэг бүртгэж, зурмаг болон натуркийг холбож ажилласан. Галт тэрэгний хөдөлгөөний гүйцэтгэсэн зурмагт хяналт тавьж, зурмагийн тасалдлын мэдээг өдөр бүр бүртгэж, тайлан мэдээг батлагдсан загварын дагуу боловсруулж, Төмөр замын газарт тайлагнаж ажиллав. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн суурь бүтэц дээрх галт тэрэгний хөдөлгөөнтэй холбоотой зурмагийн тасалдал 2025 оны 11 сарын байдлаар нийт 782 удаагийн тохиолдлоор 198226 минутын саатал бүртгэгдсэн ба нийт 903 зурмагийн тасалдал, 249516 минут бүртгэгдсэн. Төмөр замын газраас зохион байгуулсан Зурмагийн дүнгийн хуралд 2 удаа /07 сар, 11 сард/ оролцсон. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн хэмжээнд зурмагийн дүнгийн хурлыг сар бүр тогтмол хийж, үр дүнг тайлагнаж ажилласан. | |
| 1.31 | Тээврийн болон хөдлөх бүрэлдэхүүний тоон ба чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлох, галт тэрэгний хөдөлгөөний зурмаг шинжлэх, шуурхай мэдээ, хатуу тайланг гаргах, тайлагнах | Ажлын гүйцэтгэлийн хувь, Тайлангийн тоо | 2024.11.17-ны өдрийн байдлаар: Хоногийн мэдээ 323; Сайрын тайлан 11; Улирлын тайлан 3; Хагас жилийн тайлан: 2; Жилийн эцсийн тайлан 1-ийг | I-IV улирал: Хоногийн мэдээг 17:00 цагаар тасалбар болгож, тухайн өдрийн 20:00 цагийн дотор гаргаж хүргүүлсэн байна. Сар, улирал, хагас жил болон жилийн эцсийн байдлаар мэдээ, тайланг дараа сарын 10-ны | IV улирал | 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Тээврийн тоон болон чанарын үзүүлэлтүүдийн мэдээ тайланг гаргахдаа тээврийн анхан шатны бичиг баримтад тулгуулан хянаж, үнэн бодит байдлаар хоногийн мэдээг 17:00 цагаар тасалбар болгож 20:00 цагийн дотор мэдээг гарган хүргүүлж, сар, улирал, жилийн мэдээ тайланг дараа сарын 10-ны өдрийн дотор гаргаж сар болгон компанийн хэмжээнд болон төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудад тайлагнасан. 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар хоногийн мэдээ 338, сарын тайлан 11, улирлын тайлан 3, хагас жилийн тайлан 1-ийг тус тус хугацаанд нь гаргаж тайлагнан ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|--|--|---|--|---|--------------|--|-------------|
| | | | тус тус хугацаанд нь гаргаж, тайлагнан ажилласан. | өдрийн дотор гаргаж, компанийн хэмжээнд болон төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудад тайлагнасан байна. Мэдээ тайланг 100 хувь үнэн бодит гаргана. | | 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 17:00 цагийн байдлаар нийт 7,463,885.45 тонн ачаа тээвэрлэж, тээврийн төлөвлөгөөг 96%-ийн биелэлттэй байна. | |
| 1.32 | Төмөр замын зорчигч тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичиг боловсруулах | - Бодлогын баримт бичиг боловсруулах ажлын гүйцэтгэл | Засгийн Газрын 2021 оны 11 дүгээр тэмдэглэл гарсан. | II улирал: Төмөр замын Зорчигч тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн төсөл боловсруулна. III-IV улирал: Төмөр замын Зорчигч тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн төсөл батлуулна. | II-IV улирал | <i>Жич; энэ арга хэмжээ нь 1.29-тэй давхардаж байгаа.</i> | |
| Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1 дүгээр зорилтын хүрээнд төлөвлөсөн 31 арга хэмээний хэрэгжилтийг авч үзвэл 100%-тай, 27,90%-тай 2, 70%-тай 1, ү/б-1 нийт хэрэгжилт 98,3%- тай байна. | | | | | | | |
| Зорилт 2. ТӨМӨР ЗАМЫН ТӨСЛИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛНЭ. | | | | | | | |
| 2.1 | -Ханги-Номгон-Хөшигийн хөндий-Сүхбаатар чиглэлийн хоёр дахь төмөр замын төсөл, | Засгийн газар, Зам, тээврийн яамны шийдвэр гарсан эсэх | Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дугаар тогтоолоор | I-IV улирал: Шинээр эхлүүлэх төслүүдийн танилцуулга, тогтоол шийдвэрийн | I-IV улирал | Зам, тээврийн яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу Засгийн Газрын 2023 оны 404 дүгээр тогтоолоор батлагдсан "Түншлэлийн хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам"-ын дагуу | 100% |

| | | | | | | | |
|-----|---|--------------------------------------|---|--|--------------------|--|-------------|
| | <p>- Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн, Чойбалсан-Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр замын төсөл, - Сайншанд-Баруун-Урт-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төслүүдийг эхлүүлэхэд шаардлагатай анхан шатны танилцуулга, тогтоол шийдвэрийн төслүүд болон бусад шаардлагатай мэдээллүүдийг хүргүүлэх</p> | | <p>баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан.</p> | <p>төслүүд болон бусад шаардлагатай мэдээллүүдийг боловсруулж Зам, тээврийн яаманд хүргүүлсэн байна.</p> | | <p>- Солонгос улсын КОТИ төслийн хүрээнд хийгдсэн Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн төмөр замын төслийн Техник эдийн засгийн урьдчилсан судалгааны тайланд урьдчилсан үнэлгээг боловсруулсан. - Япон Улсын "Ниппон коей" компанийн 2013 онд боловсруулсан Эрэнцав-Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын инженерийн урьдчилсан зураг төсөлд эдийн засгийн тооцооллыг хийж, 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 01/13-401 дугаар албан бичиг, - "UDCG" ХХК-ны боловсруулсан Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын Техник эдийн засгийн урьдчилсан судалгаанд урьдчилсан үнэлгээг боловсруулж 2025 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 01/1331 дугаартай албан бичгээр тус тус Зам, тээврийн яаманд хүргүүлсэн.</p> | |
| 2.2 | <p>Шивээхүрэн-Сэхээ боомтыг төмөр замаар холбох /207,700.0 төгрөг/</p> | <p>Байнгын ашиглалтад орсон эсэх</p> | <p>Монголын талын барилга угсралтын ажлыг дуусгаж, байнгын ашиглалтад оруулсан.</p> | <p>I-II улирал: Хилийн өртөөдийг холбох төмөр замын барилгын ажлыг эхлүүлнэ. III-IV улирал: Шивээхүрэн-Сэхээ боомтын хил дамнасан төмөр замын барилгын ажлыг 100%-д хүргэнэ.</p> | <p>I-IV улирал</p> | <p>Монгол Улсын талаас Шивээхүрэн хилийн боомтын нарийн царигийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг цогцоор нь 100% гүйцэтгэж, Улсын комисс ажиллаж уг төмөр замыг 2024 оны 12 сард байнгын ашиглалтад хүлээн авсан. Хятадын талаас Сэхээ хилийн боомтын төмөр замыг Шивээхүрэн боомтын төмөр замтай холбох асуудал Гадаад харилцааны яам, Зам, тээврийн яамны түвшинд хэлэлцэгдэж байна.</p> | <p>100%</p> |
| 2.3 | <p>Улаанбаатар-Шинэ Хархорум чиглэлийн 384км</p> | <p>Баримт бичгийн</p> | <p>"МТЗ" ТӨХК, Солонгосын "Үндэсний</p> | <p>I-II улирал:</p> | <p>I-IV улирал</p> | <p>Солонгосын "Үндэсний төмөр зам" байгууллага нь Техник эдийн засгийн урьдчилсан судалгааг боловсруулах</p> | |

| | | | | | | | |
|-----|---|-----------------|--|--|-------------|--|-------------|
| | төмөр замын төслийг эхлүүлэх | гүйцэтгэл, хувь | төмөр зам” байгууллага хооронд 2024 оны 6-р сарын 18-ны өдөр байгуулсан харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. | ТЭЗҮ боловсруулсан байна. III улирал: ТЭЗҮ-г ЗТЯ-ны ШУТЗ-өөр хэлэлцүүлсэн байна. | | гүйцэтгэгчийг 2025 оны 5-р сард сонгон шалгаруулсан тул үйл ажиллагаа төлөвлөсөн хугацаанаас хойшлогдсон. Гүйцэтгэгч “Сусонг инженеринг” компанид Монголын талаас шаардлагатай бүх мэдээллийг ирүүлсэн жагсаалтын дагуу хүргүүлсэн. Солонгос Улсын “Сусонг инженеринг” компанийн судалгааны баг 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсад ирж “Монголын төмөр зам” ТӨХК-ийн хамтарсан ажлын уулзалт хийсэн. “Монголын төмөр зам” ТӨХК, “Сусонг инженеринг” компанийн хамтарсан судалгааны баг 2025 оны 08 дугаар сарын 03-ны өдрөөс 07-ны өдрүүдийн хооронд Улаанбаатар - Хархорин чиглэлийн төмөр замын трассын /”Монголын төмөр зам” ТӨХК-ийн боловсруулсан трассын урьдчилсан 3-н хувилбар/ дагуу газар дээр нь судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. “Сусонг инженеринг” компаниас төслийн Техник эдийн засгийн урьдчилсан судалгааны урьдчилсан тайланг 2025 оны 12-р сард ирүүлсэн. Техник эдийн засгийн урьдчилсан судалгаа боловсруулах ажил 90- ээс дээш хувьтай байна. | 90% |
| 2.4 | “Монгол-Тяньжины тээвэр логистикийн төсөл”-ийг эхлүүлэх | - Ажлын явц | Зам тээврийн Сайдаас хөрөнгө оруулагчтай байгуулсан гэрээг цуцлах чиглэл өгсний дагуу гэрээ цуцлах мэдэгдлийг 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдөр хөрөнгө оруулагчид хүргүүлсэн. | I улирал: Төсөл хэрэгжүүлэх “Монголиан порт групп” ХХК-ийн хувьцааны эрхийг Монголын тал 100 хувь авах талаар Хятадын талтай тохиролцсон байна. II улирал: Хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэсэн байна. III улирал: | I-IV улирал | 2025 оны 01 дүгээр сард төслийн санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгө оруулагчийн асуудлыг шийдвэрлэх үүрэг бүхий Зам, тээврийн яам болон бусад холбогдох яамдын хамтарсан ажлын хэсгийг байгуулсан. 2025 оны 08 дугаар сард төслийн хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхээр “Монголиан порт групп” ХХК-ийн 49%-ийн хувьцаа эзэмшигч “Монголын уул уурхайн хөрөнгийн менежмент” ХХК, тус компанид хөрөнгө оруулсан “Кингтоне Консалтинг Лимитед” ХК-ийн төлөөлөлтэй Зам, тээврийн сайд 4 удаагийн уулзалтыг зохион байгуулсан. Зам, тээврийн сайдаас “Монголиан уул уурхайн хөрөнгийн менежмент” ХХК-тай байгуулсан Хувьцаа эзэмшигчдийн гэрээг цуцлах шийдвэр өгсөн. Үүний дагуу “Монголын уул уурхайн хөрөнгийн менежмент” ХХК-ийн “Монголиан порт групп” ХХК-ийн үйл ажиллагааны зардалд 2019-2021 онд зарцуулсан 660 мянган ам.долларт аудит хийлгэх хүсэлтийг Зам, тээврийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод | 100% |

| | | | | | | | |
|-----|--|-----------------------|--|--|---------------|---|------|
| | | | | Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулсан байна. IV улирал: Төслийн ажлыг эхлүүлсэн байна. | | аудитын газарт 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдөр 01/1679 дугаартай албан бичгээр, Үндэсний аудитын газарт 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр 01/1751 дугаартай албан бичгээр холбогдох материалын хамт тус тус хүргүүлсэн. Цаашид “Кингтоне Консалтинг Лимитед” ХК нь “Монголын уул уурхайн хөрөнгийн менежмент” ХХК-ийн хувьцааг бүрэн шилжүүлж авахаар ажиллаж байна | |
| 2.5 | “Монголын төмөр зам” ТӨХК-ийн төв оффисыг орон нутагт шилжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах | - Ажлын явц | Урьдчилсан байдлаар тооцооллыг гаргаж Зам, тээврийн яаманд албан бичгээр хүргүүлсэн. | III улирал: Газрын асуудлыг шийдвэрлүүлсэн байна. IV улирал: Холбогдох судалгаа, тооцооллыг гаргаж Зам, тээврийн хөгжлийн яаманд танилцуулсан байна. | III-IV улирал | Гүйцэтгэх захирлын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А/154 дугаартай тушаалаар “Төв оффисыг орон нутагт шилжүүлэх ажил”-ыг үе шаттайгаар зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдсан. Уг ажлын хүрээнд ажлын хэсэг Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт 3 га газар авахаар судалгааг хийж, тухайн аймгуудын Засаг дарга нарт 2025. оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 01/1210 дугаартай албан бичиг, 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 03/1857 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. | 90% |
| 2.6 | Замын-Үүд сум дахь “Бүс нутгийн логистикийн төв”-ийн ашиглалт, эзэмшилтэй холбоотой үүссэн техник, технологийн болон санхүүгийн асуудлуудыг шийдвэрлэх | Ажлын гүйцэтгэл, хувь | “УБТЗ” ХНН-тэй түрээсийн гэрээ байгуулсан | I улирал: “УБТЗ” ХНН-тэй оны эхэнд гэрээ байгуулж тус төвийн тогтвортой, аюулгүй ажиллагааг хангасан байна. II улирал: “Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх төсөл”-ийн зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх гэрээний | I-IV улирал | “Улаанбаатар төмөр зам” ХНН-тэй Замын-Үүд сум дахь “Бүс нутгийн логистикийн төв”-ийг түрээслүүлэх ТҮГ-2025/05 дугаартай гэрээг 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр байгуулж түрээсийн эд хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар гарган түрээслэгч талд актаар баталгаажуулан хүлээлгэн өгсөн. Сангийн яамнаас Өрийн удирдлагын тухай хуулийн 30.7 дахь хэсгийг баримтлан дамжуулан зээлдүүлэх зээлийн ханшийн зөрүүний алдагдлыг бууруулах, гэрээний дүнг төгрөгт шилжүүлэх асуудлыг дэмжээгүй тул зээлийн эргэн төлөлтийн хуваарийг шинэчлэх талаар 2025 оны 01/2125 албан бичгээр санал хүргүүлснээр зээлийг 2037 онд бүрэн төлж дуусгах хуваарийг шинэчлэн боловсруулж 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр 2 талаас гарын үсэг зурж баталгаажуулсан. “Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх төсөл”-ийн зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх гэрээний хүрээнд компанийн зүгээс Азийн хөгжлийн банктай шууд хэлцэл хийх боломжгүй тул төвийн ашиглалт, үйл | 100% |

| | | | | | | |
|--|--|--|--|---|---|--|
| | | | | <p>ханшийн зөрүүний алдагдлын талаар зээлдүүлэгч Сангийн яамтай хэлэлцэлд орж, гэрээнд ханшийн зөрүүний алдагдлыг бууруулах өөрчлөлт оруулсан байна.</p> <p>III улирал: “Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх төсөл” ТЭЗҮ-д ашиглалт, үйл ажиллагаа, эдийн засаг, санхүүгийн талаар дахин шинжилгээ хийж техник, технологийн болон санхүүгийн асуудлуудыг Азийн хөгжлийн банктэй хэлцэл хийсэн байна.</p> <p>IV улирал: Тус төвийн ашиглалт, эзэмшилтэй холбоотой үүссэн техник, технологийн болон санхүүгийн асуудлуудыг</p> | <p>ажиллагаа, эдийн засаг, санхүүгийн үр өгөөжийг нэмэгдүүлж зээлийн эргэн төлөлттэй уялдуулах зорилгоор түрээсийн гэрээний төлбөрийг өмнөх оны түвшнээс 43%-иар нэмэгдүүлэн 5.01 тэрбум төгрөгт хүргэсэн.</p> <p>Тус төвийн ашиглалт, эзэмшилтэй холбоотой засвар сайжруулалт, хөрөнгө оруулалт, санхүүгийн асуудлуудыг шийдвэрлэх талаар холбогдох зохицуулалтыг гэрээний 1.7, 1.9.3-т тусган хэрэгжүүлж байна. Мөн тус төвийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалтын байдалд хяналт тавих зорилгоор Гүйцэтгэх захирлын 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/265 тоот тушаалаар байгуулсан тооллогын комисс тус төвийн эд хөрөнгийн тооллогыг 11 дүгээр сарын 19-20-ны өдөр зохион байгуулсан.</p> | |
|--|--|--|--|---|---|--|

| | | | | | | | |
|---|---|---|---|---|------------------|---|------|
| | | | | шийдвэрлэсэн байна. | | | |
| Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2 дугаар зорилтын хүрээнд төлөвлөсөн 6 арга хэмээний хэрэгжилтийг авч үзвэл 100%-тай 4,90%-тай 2 нийт хэрэгжилт 96.6%- тай байна. | | | | | | | |
| Зорилт 3. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГЫГ ХАНГАЖ АЖИЛЛАНА. | | | | | | | |
| 3.1 | Ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах | Эрүүл мэндийн үзлэгт хамруулсан /599 ажилтан/ | 2024.11.21-ний өдрийн №2024-ҮҮГ/62 дугаартай гэрээний дагуу 300 ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан. | II улирал: Гүйцэтгэгч байгууллагыг сонгож, гэрээ байгуулсан байна. III улирал: Ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд 599 ажилтан хамруулна. | II-III улирал | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 103 дугаар тогтоолын дагуу “Монголын төмөр зам” ТӨХК, “Тавантолгой төмөр зам” ХХК-уд нэгдсэнтэй холбоотойгоор Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр ТУЗ-ийн хурлаар тодотгол хийгдсэн. Ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах тендер 2025 оны 8 дугаар сарын 06-ны өдөр зарласан. Уг тендерийг 8 дугаар сарын 27-ны өдөр нээхэд 7 оролцогч оролцсон. Оролцогчид тендерийн баримт бичгийн шаардлага хангаагүй тул захиалагчид зөвлөмж хүргүүлж тендерийг дахин зарласан. Дахин зарлахад 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр нээхэд 9 оролцогч орж ирсэн боловч шаардлага хангах тендер байгаагүй тул 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдөр дахин зарласан. | 90% |
| 3.2 | Ажилтнуудыг хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр хангах | Ажлын явц | 423 ажилтанд хөдөлмөр хамгааллын хувцас олгосон. | I улирал: Батлагдсан орон тооны хүрээнд ажилтнуудад 200 ш дүрэмт хувцас олгосон байна. II улирал: Батлагдсан орон тооны хүрээнд ажилтнуудад 457 ш зуны хувцас олгосон байна. IV улирал: Батлагдсан орон тооны хүрээнд ажилтнуудад 457 | I, II, IV улирал | Үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлээс хамгаалах бүхий өвлийн ажлын тусгай хувцас, ажлын гутлаар хангагдаагүй зориулалтын бус хувцастай ажил үүрэг гүйцэтгэж байгаа 541 ажилтнуудыг ХАБЭА-н тухай хуулийн 15.1-т заасны дагуу өвлийн гутал, хувцас, тусгай хэрэгслээр хангасан. | 100% |

| | | | | | | | |
|-----|---|-----------|---|--|------------------|---|------|
| | | | | ш өвлийн хувцас олгосон байна. | | | |
| 3.3 | Эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа ажилтнуудын амь, нас, эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах | Ажлын явц | “MIG” даатгал ХХК-тай ҮҮГ-2024/60 дугаартай гэрээний дагуу 390 ажилтнуудыг эрүүл мэндийн даатгалд хамруулсан. | I улирал: Эрсдэлтэй ажлын байрны судалгаа, тоог гаргасан байна. III улирал: Гүйцэтгэгч байгууллагыг сонгож, гэрээ байгуулсан байна. IV улирал: Эрсдэлтэй ажлын байрны судалгааны үндсэн дээр амь, нас, эрүүл мэндийн даатгалд ажилчдыг хамруулсан байна. | I, III-IV улирал | Судалгаагаар эрсдэлтэй 31 ажлын байранд ажиллаж байгаа 715 ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулахаар техникийн даалгавар боловсруулан худалдан авах хэлтэст хүргүүлсэн. 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр нээлттэй тендер зарласан. 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр сонгон шалгаруулалтыг хийхээр төлөвлөсөн. | 90% |
| 3.4 | Төмөр замын хөдөлгөөнтэй шууд холбоотой ажлын байруудад эрсдэлийн үнэлгээ хийх, шинэчлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих | Ажлын явц | 30 ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийсэн. | II улирал: Төмөр замын хөдөлгөөнтэй шууд холбоотой ажлын байруудад эрсдэлийн үнэлгээ хийх төлөвлөгөө боловсруулж, батлуулсан байна. III улирал: Эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг зохион | II-IV улирал | Төмөр замын хөдөлгөөнтэй шууд холбоотой 31 ажлын байранд эрсдэлийн үнэлгээг хийж, болзошгүй осол гэмтэл, түүнээс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдалд үзлэг шалгалт хийж, хяналт тавьж ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|-----|--|------------------------|----------------------------|---|---------------|--|------|
| | | | | байгуулсан байна. IV улирал: 10 ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийж хяналт тавьж гүйцэтгэнэ. | | | |
| 3.5 | Аюултай хог хаягдал түр хадгалах цэг байгуулах, хог хаягдлын чиглэлээр орон нутагтай гэрээ байгуулан ажиллах, хяналт тавих | Ажлын явц | - | I улирал: Аюултай хог хаягдал түр хадгалах цэгийн техникийн тодорхойлолтыг гаргана. Хог хаягдлын чиглэлээр орон нутгийн байгууллагатай гэрээ байгуулсан байна. II улирал: Аюултай хог хаягдлын цэг байгуулах ажлын худалдан авалтыг зохион байгуулж, гэрээ хийнэ. Цогтцэций депод 1 аюултай хог хаягдлын цэг байгуулсан байна. | I-II улирал | 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр “Глобал Гэйтвэй” ХХК-тай гэрээ байгуулж, Цогтцэций депод аюултай хог хаягдал түр хадгалах цэг байгуулсан. | 100% |
| 3.6 | Төмөр замын суурьшлын бүсийг түшиглэн ногоон байгууламж болон | Тарих модны тоо /9000/ | 10 050 ширхэг мод тарьсан. | II улирал: 4000 ширхэг мод IV улирал: 9000 ширхэг мод тарьсан байна. | II, IV улирал | Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Монголын Төмөр Зам” ТӨХК нь 2025 оны төлөвлөгөөнд тусгасны дагуу 2025 оны 05 дугаар сарын 24-ний өдөр 5200 ширхэг сухай, жигд, хайлаас модны суулгацыг тарьсан. | 100% |

| | | | | | | | |
|---|--|----------------|--|---|-------------|--|------|
| | ойн зурвас байгуулах | | | | | 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 5000 ширхэг сухай, жигд, хайлаас модны суулгацыг тарьж арчлалт хамгаалалтыг хийж байна. | |
| Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3 дугаар зорилтын хүрээнд төлөвлөсөн 6 арга хэмээний хэрэгжилтийг авч үзвэл 100%-тай 4,90%-тай 2 нийт хэрэгжилт 96.6%- тай байна. | | | | | | | |
| Зорилт 4. АЖИЛТНУУДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАНА. | | | | | | | |
| 4.1 | Компанийн 30 хүртэлх ажилтныг орон сууцны ипотекийн зээлд хамруулах ажлыг зохион байгуулах | - Ажлын явц | 28 ажилтны ипотекийн зээл шийдвэрлэгдсэн | I улирал: Шаардлага хангасан 7 ажилтны материалыг Худалдаа хөгжлийн банканд хүргүүлнэ. II улирал: Шаардлага хангасан 14 ажилтны материалыг Худалдаа хөгжлийн банканд хүргүүлнэ. III улирал: Шаардлага хангасан 21 ажилтны материалыг Худалдаа хөгжлийн банканд хүргүүлнэ. IV улирал: Шаардлага хангасан 58 ажилтны материалыг Худалдаа | I-IV улирал | Гүйцэтгэх захирлын 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/205 дугаартай тушаалаар ажилтнуудыг ипотекийн зээлд хамруулах сонгон шалгаруулалт хийх ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн тавигдах шалгуурын дагуу ажилтнуудын ирүүлсэн өргөдлийг эрэмбэлэн шалгаруулж 55 ажилтны өргөдлийг холбогдох материалын хамт Худалдаа хөгжлийн банкинд хүргүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|-----|---|-------------------------------------|---|--|---------------|---|------|
| | | | | хөгжлийн банканд хүргүүлнэ. | | | |
| 4.2 | Нийт ажилтнуудын үндсэн цалинг 10 хүртэлх хувиар нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах | - Үндсэн цалин нэмэгдүүлсэн эсэх | - | I улирал: Батлагдсан орон тооны дагуу ажилтнуудын үндсэн цалинг нэмэгдүүлэх тухай шийдвэр гарсан байна. II улирал: Шийдвэрийг хэрэгжүүлж эхэлсэн байна. | I-II улирал | Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд “Тавантолгой төмөр зам” ХХК-иас шаардлагатай чиг үүрэг, орон тоог шилжүүлэн авахыг “Монголын төмөр зам” ТӨХК-д даалгасан. Энэ хүрээнд компанийн ТУЗ-ийн 2025.04.08-ны өдрийн “Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарын тухай” 09 дүгээр тогтоол, 80 ТӨБЗГ-ын 2025.04.17-ны өдрийн ““Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг өөрчлөн батлах тухай”” 09 дүгээр тогтоолоор компанийн бүтэц, орон тоо шинэчлэн батлагдсан. Төмөр замын тээврийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах буюу “Тавантолгой төмөр зам” ХХК-аас шилжин ажиллах ажилтнуудын үндсэн цалинг бууруулахгүйгээр шилжүүлэн авах хүрээнд Компанийн үндсэн цалингийн сүлжээг 9-13 хувиар шинэчлэн баталж, Гүйцэтгэх захирлын 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/74 дугаартай “Албан тушаалын цалингийн сүлжээ шинэчлэн батлах” тухай тушаалыг баталсан. | 100% |
| 4.3 | Гэр хороололд амьдардаг ажилтнуудад түлээ, нүүрсний хөнгөлөлт үзүүлэх | Хөнгөлөлт үзүүлсэн эсэх | 183 ажилтанд түлээ, нүүрсний хөнгөлөлт үзүүлсэн | III улирал: Гэр хороололд амьдардаг ажилтнуудын судалгааг гаргана. IV улирал: Гэр хороололд амьдардаг ажилтнуудад түлээ, нүүрсний хөнгөлөлт үзүүлсэн байна. | III-IV улирал | Төвлөрсөн халаалтгүй, байнгын галлагаатай гэр, байшинд амьдардаг ажилтнуудын судалгаанд үндэслэн төсөвт тусгагдсаны дагуу Гүйцэтгэх захирлын 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/286 дугаар тушаалаар түлээ нүүрсний дэмжлэгийг компанийн 383 ажилтанд үзүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|--|--|----------------------|---|--|-------------|---|------|
| 4.4 | Компанийн ээлжийн ажилтнуудыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн чанартай хоол ундаар үйлчлэх, амрах байраар хангах. | - Ажлын гүйцэтгэл | 2024 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар давхардсан тоогоор 79,750 инженер техникийн ажилтан Тавантолгой өртөөнд 115,717, Гашуунсухайт өртөөнд 45,849 хоолны захиалга тус тус хийгдэж хоол хүнсээр үйлчилсэн байна. | IV улирал: Ажилтнуудад эрүүл ахуйн шаардлагад нийцсэн чанартай хоол ундаар үйлчилж, тав тухтай ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ. | IV улирал | Тавантолгой, Гашуунсухайт, Цогтцэций өртөөнүүдэд 960 гаруй инженер, техникийн ажилтнуудад “Титан хас фүүдс” ХХК болон Цогтцэций өртөөн дэх “Сант гэсэр” ХХК-ний кейтрингийн зүгээс эрүүл ахуйн шаардлага хангасан өглөө, өдөр, орой, шөнийн хоолоор үйлчлэн, тав тухтай ажиллаж, амьдрах орчин нөхцөлөөр ханган ажиллаж байна. Мөн удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу зарим өртөө, зөрлөгийн амрах байруудыг засварлах ажлын хүрээнд Бор хошуу зөрлөгийн 14 айлын орон сууц, Цогтцэций өртөөний 120 орон айлын орон сууц, Хулангийн шанд зөрлөгийн өртөөний байр, Гашуунсухайт өртөөний амрах байрны дээврийн засвар, Тавантолгой өртөөний түр ачилтын талбайн байр, Хунхарзаг өртөөний дээврийн засвар, тохижилтын ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн. | 100% |
| Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4 дүгээр зорилтын хүрээнд төлөвлөсөн 4 арга хэмээний хэрэгжилт 100%-тай байна. | | | | | | | |
| Зорилт 5. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХЫГ ДЭЭШЛҮҮЛЖ, КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОЛОН НИЙТЭД СУРТАЛЧЛАН ТАНИУЛЖ ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛНЭ. | | | | | | | |
| 5.1 | Хүний нөөцийн чадавх, мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр ХАБЭА, авлигын болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мэдээлэл | Сургалтын тоо | 20 удаа сургалтыг зохион байгуулсан. | I улирал: 5 удаа II улирал: 10 удаа III улирал: 15 удаа IV улирал: 20 удаа сургалт хийх | I-IV улирал | 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Компанийн сургалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан. Төлөвлөгөөний дагуу I-III улиралд нийт 22 сургалтыг зохион байгуулж ажилтнуудад зохих мэдлэгийг олгосон. IV улиралд дараах сургалтуудыг зохион байгууллаа. Дотоод сургалт: 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих холбооны сургалт; 2. Төмөр замын тоног төхөөрөмж ашиглах, тэдгээрийн арчлалт, хамгаалалт; | 100% |

| | | | | | | | |
|-----|---|--|--|--|-------------|---|------|
| | технологи, инженер, техникийн ажилтнуудыг мэргэшүүлэх, архив, албан хэрэг хөтлөлтийн болон бусад сургалтыг зохион байгуулах | | | | | <ol style="list-style-type: none"> 3. Автоматжуулалт SCADA-ийн сургалт; 4. Даралтат савны ашиглалт, засвар, үйлчилгээний сургалт; 5. Үл эвдэх сорилын сургалт 6. Газрын доорх усны чанарын хяналт ба сорьц авах арга зүйн сургалт; 7. Өртөө зөрлөгүүдэд “Эрүүл монгол, эрүүл бие” сургалт; 8. Краны сургалт; 9. Электроникийн сургалт; 10. Токарийн сургалт; 11. Хүний нөөцийн мэргэшүүлэх HRL-1 хөтөлбөр; 12. Архив албан хэрэг хөтлөлтийн сургалт; 13. Үйлчлэгчийн эрхийн сургалт; 14. Хүүхдийн эрхийг хамгаалах сургалт; 15. ХАБЭА-ийн багц сургалт; 16. Галт тэрэгний найруулагч;Өртөөний жижүүр 17. Хөдөлмөрийн тухай хуулийн сургалт; 18. Авлигатай тэмцэх газраас явуулсан Эрх бүхий албан тушаалтны хамрагдах 3 удаагийн давтамжит сургалт; <p>Гадаад сургалт:</p> <ol style="list-style-type: none"> 1.БНХАУ-ын Бугат хотын Төмөр замын техникийн коллежид 8 оюутныг сургуульд нь хүргэн сургуулийн удирдлага, сургалтын орчинтой нь танилцуулж, бүртгэлийг хийлгэсэн. 2. БНХАУ-ын Бугат хотын Төмөр замын техникийн коллежид 20 ажилтныг Гагнуурчны ахисан түвшний богино хугацааны сургалтад хамрууллаа. | |
| 5.2 | “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн төмөр замын салбартай холбоотой арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах | - “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж ажиллах | | <p>I улирал: “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулсан байна.</p> <p>IY улирал: Батлагдсан төлөвлөгөө бүрэн</p> | I-IV улирал | <p>2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн Гүйцэтгэх захирлаар батлуулсан төлөвлөгөөний дагуу тайлант хугацаанд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуульд заасан хугацаанд нь байршуулж, ил тод байдлыг ханган ажилласан. 2. Бүтэц зохион байгуулалт шинэчлэгдэж албан тушаалын өөрчлөлтэй эрх бүхий албан тушаалтныг Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг хянуулсан-9, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргасан-9, Их хэмжээний өөрчлөлтийн мэдүүлэг гаргасан-1 тус тус баталгаажуулсан. | 100% |

| | | | | | | | |
|-----|--|---|--|---|-------------|--|------|
| | | | | хэрэгжсэн байна. /100%/ | | 3. Авлигатай тэмцэх газрын нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн мэдүүлгийг бүртгэх нэгдсэн программын шинэчлэлтэй холбоотойгоор компанийн ЭБАТ болон ХАСХОМ мэдүүлэгч албан тушаалтнуудыг сургалтад хамруулж мэдээлэл хүргэсэн. | |
| 5.3 | “Монголын төмөр зам” ТӨХК-ийн хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд, бодлого шийдвэрүүд, үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй сурталчлан таниулах | Олон нийтэд түгээсэн мэдээ, мэдээллийн тоо | 100 удаагийн мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээсэн. | I улирал: 25 удаа II улирал: 50 удаа III улирал: 75 удаа IV улирал: 100 удаа мэдээ нийтэлнэ. | I-IV улирал | 2025 оны эхний 11 сарын байдлаар “Монголын төмөр зам” ТӨХК-ийн албан ёсны фэйсбүүк хуудсаар нийт 219 пост нийтлэгдэж, эдгээр нь давхардсан тоогоор 8,878,438 удаа олон нийтэд харагдсан байна. Тухайн постууд дээр нийт 74,064 үйлдэл хийгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 167%-иар өссөн үзүүлэлт юм. Мөн байгууллагын цахим хуудсаар зочилсон давтамж 182,708 хүрч 82%-ийн өсөлт, цахим хуудасны дагагчдын тоо 12,504-иар нэмэгдэж 216%-ийн өсөлт үзүүлжээ. Гэрээт хэвлэл мэдээллийн байгууллагууд болох gogo.mn - 13 мэдээ, Eagle телевиз - 7 мэдээ, eduur.mn - 25 мэдээ, ubn.mn - 28 мэдээ, zarig.mn - 25 мэдээ, urug.mn - 27 мэдээ, mass.mn - 20 мэдээ, tovch.mn - 21 мэдээ нийтлэн, агуулга давхардсан тоогоор нийт 339 албаны мэдээ, нийтлэл, постер, видео материал олон нийтэд хүрсэн. | 100% |
| 5.4 | Компанийн 2025 оны худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг худалдан авах тухай хуульд заасны дагуу зохион байгуулах | Зохион байгуулсан худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 90 хувь | I-IV улирал: 100 хувь | I-IV улирал | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 247 дугаар тогтоолын дагуу Компанийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулан 220,323,341,078 (хоёр зуун хорин тэрбум гурван зуун хорин гурван сая гурван зуун дөчин нэгэн мянга далан найм) төгрөгийн төсөвт өртөг бүхий 209 төсөл арга хэмжээг төлөвлөн Гүйцэтгэх захирлын 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/92 дугаартай тушаалаар батлуулсан. Батлагдсан төлөвлөгөө болон төлөвлөгөөнд орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүрд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, хуульд заасан хугацаанд багтаан төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нийтэлсэн. 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар 43 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий хөрөнгө оруулалтын шинж чанартай 32 төсөл арга хэмжээ, 66 тэрбумын төсөвт өртөг бүхий капиталжих зардлын шинжтэй 1 төсөл арга хэмжээ, зардлын шинж чанартай 88 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 76 төсөл арга хэмжээг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---------------------------|--|--|---------------|---|------|
| | | | | | | худалдан авах ажиллагааны хуулийн хүрээнд зохион байгуулж ажилласан. | |
| Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 5 дугаар зорилтын хүрээнд төлөвлөсөн 4 арга хэмээний хэрэгжилт 100%-тай байна. | | | | | | | |
| Зорилт 6. ДОТООД АУДИТ, ТЭЭВРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙЖ, ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА ӨГӨХ ЗАМААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙГ АРИЛГУУЛЖ, АЖЛЫГ САЙЖРУУЛНА. | | | | | | | |
| 6.1 | Компанийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон худалдан авах үйл ажиллагааны гүйцэтгэл, шилэн дансны мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, холбогдох журмын дагуу үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэгдсэн байдал, зарим эд хөрөнгийн үнэн зөв байдал, хадгалалт, зарцуулалтад дотоод аудитын хийнэ. | Дотоод аудит 9 хийсэн тоо | Дотоод аудитын чиглэлээр 2024 онд 7 удаагийн хяналт шалгалтыг хийсэн | II улирал: Дотоод аудитыг 4 удаа IV улирал: Дотоод аудитыг 9 удаа хийсэн байна. | II, IV улирал | Компанийн санхүүгийн сахилга батыг нэмэгдүүлэх зорилгоор төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус байдлаар 9 удаагийн дотоод аудит хийж, 25 зөвлөмж, албан шаардлага өгч 5 ажилтанд хариуцлага тооцож шийдвэрлэсэн. Мөн хөндлөнгийн аудитын байгууллагаас 2024 онд өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн тоог өмнөх оноос бууруулж ажилласан. Аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг гаргаж, нотлох баримтын хамт нийт 667 хуудас бүхий баримт материалыг 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 01/1716 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт, 01/1715 дугаар албан бичгээр ЗТЯ-ны ХШҮДАГ, 01/1717 дугаар албан бичгээр ТӨБЗГ-т тус тус хүргүүлсэн. Мөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг Төрийн аудитын байгууллагын fas.audit системд хяналтыг тавин ажилласан. - Компанийн 2024 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 100 хувь ханган биелүүлж, тайланг хугацаанд нь гаргаж 2025 оны 01 дүгээр сарын 14-ний 01/01-64 дугаар албан бичгээр, 2025 оны I улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайланг охин компаниудаас ирсэн мэдээний хамт 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 01/01-560 дугаар албан бичгээр, 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 01/1201 дугаар албан бичгээр II улирлын тайлан, 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 01/2144 дугаар албан бичгээр III улирлын тайланг ЗТЯ-ны Тээврийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус хүргүүлсэн. Өнөөгийн байдлаар цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш орлогын 303 удаагийн 186,640.6 сая төгрөгийн, зарлагын 1012 удаагийн 119,635.8 сая төгрөгийн гүйлгээ, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний 77,395.9 сая төгрөгийн | 100% |

| | | | | | |
|--|--|--|--|--|---|
| | | | | | <p>батлагдсан төсөвтэй, 64,879.7 сая төгрөгөөр гэрээ нь байгуулагдсан 58 тендерийн ерөнхий мэдээлэл мөн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтыг нийлүүлэгчийн нэр тусгагдсан арга хэмжээний 245,610.5 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй, 241,522.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 1429 удаагийн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт хийгдэж, хугацаа мөрдөлтөд хяналт тавьж ажилласан. Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д заасны дагуу 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд мэдээлбэл зохих 168 мэдээллийн 163 удаагийн давтамжтайгаар мэдээлж, хугацаа болоогүй 5 мэдээлэл, нэгдсэн дүнгээр хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна.</p> <p>Мөн охин компаниуд шилэн дансны тайлангаа Зам, Тээврийн яаманд шууд хүргүүлж байгаа тохиолдолд манай компани тайланг нэгтгэн авч дахин хүргүүлэхгүй байх, “Монголиан порт групп”-ын шилэн дансанд бүртгүүлэх хүсэлтийг уламжилж өгнө үү гэсэн 2 саналыг хүргүүлсэн. * Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах шилэн дансны Shilendans.gov.mn вэб сайтад мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулах талаар “Тавантолгой төмөр зам” ХХК, “Шивээхүрэн” ХХК, Монголиан порт групп” ХХК тус бүрийн хариуцсан албан тушаалтанд арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Зам, Тээврийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээчээс 2024 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайлан, мэдээг хянаад өгсөн арга зүйг холбогдох мэдээлэл оруулах талаар 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтэс, Худалдан авалтын хэлтэс, Хүний нөөц, сургалтын хэлтэст тус тус мэргэжил арга зүйн зөвлөмжийг хүргүүлсэн.</p> <p>Мөн Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын дагуу компаний үйл ажиллагааны үнэлгээг улирал бүр дүгнэн ЗТЯаманд хүргүүлж ажиллав.Мөн компаний чиг үүрэгт дүн шинжилгээ хийж, албан хаагчдын ажлын ачаалалыг</p> |
|--|--|--|--|--|---|

| | | | | | | | |
|-----|--|----------------------------------|--|---|---------------|---|------|
| | | | | | | тооцон, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлуулав. | |
| 6.2 | Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилтын хүрээнд холбогдох хууль дүрмийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах замаар осол, гологдол зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллана. | 46 удаагийн хяналт шалгалт хийнэ | Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор хяналт шалгалтыг 63 удаа зохион байгуулсан | II улирал: 23 удаа IV улирал: 46 удаа зохион байгуулсан байна. | II, IV улирал | Гүйцэтгэх захирлын баталсан хуваарийн дагуу хяналтын байцаагчид Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд байрлах Төмөртэй өртөө, Өмнөговь, Дорноговь аймгийн нутаг дэвсгэрийг дамнан байрлах Цогтцэций өртөө, 6 зөрлөг, Тавантолгой-Гашуунсухайт түүний хэсэглэлд 14/14 хоногоор албан томилолтоор ажилладаг ба 2025 оны IV улирлын байдлаар Цогтцэций өртөө, Тавантолгой-Гашуун сухайт өртөө түүний хэсэглэлд 55, Төмөртэй өртөөнд 25 нийт 80 удаа нийт давхардсан тоогоор 638 хоног шугам замд ажилласан. Ажилтнуудын мэдлэг ур чадварыг дээшлүүлэхэд тогтмол анхаарч томилолтоор ажиллах хугацаандаа хяналтын байцаагч нар галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд болон шууд бус холбоотой ажилтнуудад сургалт зохион байгуулсан бөгөөд Цогтцэций өртөө, Тавантолгой-Гашуунсухайт түүний хэсэглэл, Төмөртэй өртөөнд давхардсан тоогоор нийт 315 ажилтанд нийт 106 цагийн сургалт зохион байгуулсан. Байцаагч нар томилолтоор ажиллах хугацаанд Цогтцэций өртөө, Тавантолгой-Гашуунсухайт түүний хэсэглэл, Төмөртэй өртөөнд нийт 651 үл тохирлыг цаг тухай бүр газар дээр нь арилгуулсан. Хяналтын байцаагч нар шугам замд томилолтоор ажиллах хугацаанд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах хүрээнд Цогтцэций өртөө, Тавантолгой-Гашуунсухайт, Төмөртэй түүний хэсэглэлд давхардсан тоогоор нийт 47 удаагийн 211 үүрэг даалгаврыг байцаагчийн заалтын дэвтэрт бичиж өгснөөс нийт 182 төрлийн хугацаатай үүрэг даалгаврыг өгсөн бөгөөд үүрэг даалгавар 97.1 хувийн хэрэгжилттэй. | 100% |
| 6.3 | Компанийн суурь бүтцээр тээвэрлэгдэж байгаа аюултай ачааны хамгаалалт, төмөр замын объект, тусгай бүс, Гаалийн хяналтын | - Төлөвлөгөөний хэрэгжилт | 2024 онд хамгаалалтын н 11цэгт 72008 хүн/цаг ажиллан өртөө болон Шилжүүлэн ачих | I улирал: Хариуцсан нэгжийн 2025 оны хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг | I-IV улирал | 2025 онд хамгаалалтын 10 цэгт 81600 хүн/цаг ажиллан өртөө болон Шилжүүлэн ачих терминал, Гаалийн хяналтын талбайд 127288 автомашин, 100384 хүнийг шалган нэвтрүүлж, Гаалийн хяналтын талбайд 23411 автомашиныг байрлуулан хөдөлгөөн зохицуулалт хийсэн. Гаалийн байцаагчийн зөвшөөрлөөр гаалийн хяналтын талбайгаас 188936 ачаатай чингэлэгтэй нүүрс тээврийн 47234 автомашинд тулгалт хийж, хилийн боомт руу нэвтрэх үед Гашуунсухайт 6 замын уулзварт 113898 | 100% |

| | | | | | | | |
|--|---|--|---|--|--|--|--|
| | <p>талбайн аюулгүй байдлыг хангаж ажиллана.</p> | | <p>терминал, Гаалийн хяналтын талбайд 48044 автомашин, 35733 хүнийг шалган нэвтрүүлж, Гаалийн хяналтын талбайд 30156 автомашины г байрлуулан хөдөлгөөн зохицуулалт хийсэн. Гаалийн байцаагчийн зөвшөөрлөөр гаалийн хяналтын талбайгаас нүүрс тээврийн 24940 автомашин гарах үед 99760 чингэлгийн дугаар тулгалт хийж нэвтрүүлсэн. Өртөөний зам паркад 1729 вагон цистерн, 37 битүү вагонтой</p> | <p>ханган ажиллана. I-IV улирал: Төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээний дагуу үйл ажиллагааг зохион байгуулна.</p> | | <p>автомашин хөдөлгөөнд зохицуулалт хийж нэвтрүүлсэн. Өртөөний зам паркад 3227 вагон цистерн, 46 битүү вагонтой тэсэлгээний бодис /амоны нитрат/ ирэх үед ачаа вагон хүлээлцэгч нараас хүлээн авч аюултай ачаа вагонд хамгаалалт хийж ажилласан.</p> | |
|--|---|--|---|--|--|--|--|

| | | | | | | | |
|--|---|-----------------------------------|--|---|---------------|---|------|
| | | | тэсэлгээний бодис /амоны нитрат/ ирэх үед ачаа вагон хүлээлцэгч нараас хүлээн авч аюултай ачаа вагонд хамгаалалт хийж ажилласан. | | | | |
| 6.4 | Суурь бүтэц эзэмшигч байгууллагуудын хооронд ачааны хэмжээ тохирох хурлыг оролцоно. | - Хурал зохион байгуулсан эсэх | Хуралд оролцох бэлтгэл ажлыг ханган ажиллана. | III-IV улирал Бүх төмөр замын байгууллагуудын тухайн жилд ямар төрлийн хэдэн тонн хэмжээний ачаа, барааг суурь бүтэц эзэмшигч хоорондоо тээвэрлэх талаар тохирох хурлыг зохион байгуулна | III-IV улирал | “Суурь бүтцээр дамжин өнгөрөх ачааны хэмжээ тохиролцох IV зөвлөгөөн”-ийг 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Төмөр замын байгууллагуудын дунд Улаанбаатар хотод зохион байгуулсан. Зөвлөгөөнөөр Монгол Улсын төмөр замын суурь бүтэц эзэмшигч байгууллагууд 2026 онд төмөр замаар тээвэрлэх ачааны хэмжээ, хөдөлгөөний зохион байгуулалт, ачаа тээвэр, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт, төлбөр тооцоо зэрэг асуудлаар харилцан тохиролцсон. | 100% |
| Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 6 дугаар зорилтын хүрээнд төлөвлөсөн 4 арга хэмээний хэрэгжилт 100%-тай байна. | | | | | | | |

Дүгнэлт: 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 6 зорилтын хүрээнд 55 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнээс 100 хувийн биелэлттэй 47, 90 хувийн биелэлттэй **6**, 70 хувийн биелэлттэй 1, үнэлэх боломжгүй **1** арга хэмжээ байна. Төлөвлөгөөний хэрэгжилт жидийн байдлаар **98.3** хувийн биелэлттэй буюу зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, төсөв санхүүгийн асуудлыг шийдэж зохион байгуулалтын арга хэмжээ авсан гэсэн дүгнэлттэй байна.

---000---

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

2025.12.10

Хавсралт-3

| Шийд- вэрийн Д/д | Заалт Д/д | | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц | Биеллэлт гаргах нэгж | Хувь |
|-------------------------------|--------------|--|--|--|-------------------------|------|
| Засгийн газрын тогтоол | | | | | | |
| | 8 | Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн талаар авах арга хэмжээний тухай 2022-11-30 Дугаар 2022_434 | 4.Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас оруулсан хөрөнгө, санхүүжилтийг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн тээвэрлэлтийн үйл ажиллагааны орлого, холбогдох бусад эх үүсвэрээс барагдуулах арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү)-д тус тус даалгасугай. | “Монголын төмөр зам” ТӨХК нь орлогын эх үүсвэр нь ачаа тээвэрлэлт, төрийн өмчийн түрээсээр олдог. 2025 оны 02 дугаар сарын байдлаар 3,007.4 мянган тн. ачаа тээвэр хийж 106.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн бөгөөд 2025 онд БНХАУ-ын “Чайна энерги коксжих нүүрс” ХХК-тай урт хугацааны нүүрс тээвэрлэлтийн гэрээ байгуулж тээвэрлэлтийг хийж эхэлснээр Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн эргэн төлөлтийг гэрээний дагуу 2027 оноос төлж эхлэх нөхцөл бүрдэж байна. Цаашид ачаа тээвэрлэлтийг нэмэгдүүлэн, зүтгүүрийн парк шинэчлэлт болон тоог нэмэгдүүлэх үе шаттай арга хэмжээ авч компаниас төлөх зээлийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу төлөхөөр төлөвлөн ажиллаж байна. | СНББХ | 100% |
| 80 | 116 | Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, гадаад валютын улсын нөөцийг өсгөх чиглэлээр | 1.2.Тавантолгойн нүүрс ачих логистикийн төвийн үйл ажиллагааг сайжруулан хоногт 8-аас багагүй галт тэргэнд нүүрсний | 2024.06.11-ний өдөр ачилт хийж эхэлсэн. 2025 онд 1830 вагон, 117,892.47 тонн, нийт 41 галт тэрэг, 2016 вагон, 129.853.1 тонн ачаа тээвэрлэсэн. ТНАЛТ /Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв/-н үйл ажиллагаанд өнөөдрийг хүртэлх хугацаанд хийсэн судалгаагаар /дунджаар 51 вагон/ - цэвэр жин - 3286.8 тонн, | ТУГ | |

| | | | | | | |
|-----------------------------------|-----|---|---|--|------|------|
| | | авах зарим арга хэмжээний тухай 2025-03-19 Дугаар 2025_135 | ачилт хийж тээвэрлэх, цаашид ачилтын тоог нэмэгдүүлэх ажлыг 2025 оны 04 дүгээр сард багтаан зохион байгуулахыг “Эрдэнэс Тавантолгой” ХК (Х.Мөнхжаргал), “Монголын төмөр зам” ТӨХК (О.Батчулуун)-д; | - бохир жин - 3487.4 тонн ачсан, - ачилтын үед саатсан цаг 1.6 цаг, - ачилтын цэвэр хугацаа 4.1 цаг, - ачилтын бохир хугацаа 6.5 цаг, - нийт ачилтын дундаж хугацаа 9.51 цаг байна. Бункерт ачааны нөөц бүрдүүлэлт хүлээгдсэн, систем алдаа заасан, автоматжуулалтын алдаа гарсан, автомат удирдлагын системд алдаа заасан, тоног төхөөрөмж хяналтын алдаа заасан, автомат уналтын алдаа заасан, ачааны овоолго хүрэлцээгүй, бункер тэжээх ковш жижиг байсан, талбайд байсан нүүрс овоолготой удсанаас болж дагтаршил үүсэж реклемэрт нүүрс хамагдахгүй байсан, дамар нь эргэхгүй болж саатсан, тоног төхөөрөмж асахгүй, ачилтын явцад бункерийн хаалт гацсан гэх зэрэг эвдрэл гэмтэлтэй холбоотой асуудлыг Эрдэнэс тавантолгой ХХК яаралтай шийдвэрлэх шаардлагатай байна. ТНАЛТ-ын үйл ажиллагаа жигдрэхгүй байгаагаас шалтгаалан хоногт 8-аас багагүй галт тэргэнд нүүрсний ачилт хийж тээвэрлэх ажил биелээгүй байна. | | 100% |
| 88 | 134 | Төмөр замын барилгын ажлын зөвшөөрөл олгох 2025-05-07 Дугаар 2025_230 | 4. 4.Төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, явц, үр дүнг тухай бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, “Монголын төмөр зам” ТӨХК (О.Батчулуун)-д үүрэг болгосугай. | Засгийн газрын 230 дугаар тогтоолын дагуу Багахангай-Хөшгийн хөндий чиглэлийн салбар төмөр замын барилгын ажлын гүйцэтгэгч нарыг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгож бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн. Төслийн хүрээнд газар шорооны ажил 93,17%, дам нуруут гүүрийн ажил 84,0%, ухмал байгуулах ажил 95,95%, дугуй хоолойн ажил 75,36%, дөрвөлжин хоолойн ажил 59,86% -ийн гүйцэтгэлтэйгээр ажиллаж байна. мөн эхний 7 км дээд бүтцийн угсралтын ажлыг гүйцэтгэж байна. | ТХСГ | 90% |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | |
| 122 | 187 | 2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл | ХИ.1.1. Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх | "Монголын төмөр зам" ТӨХК-ийн өөрийн эзэмшлийн нийт 215 хагас вагон байгаагаас 50 хагас вагоныг "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн Төмөртэй-Эрээн чиглэлийн экспортын төмрийн хүдэр тээвэрлэлтэд ашиглаж, үлдсэн 165 | ТУГ | 100% |

| | | | | | | |
|--|--|--------------------------------------|--|---|--|--|
| | | <p>2023-03-07 Дугаар 2023_11</p> | <p>чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 362 дугаар тогтоолын хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний талаар Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:</p> <p>1.Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн эзэмшилд байгаа ачааны хагас вагоны хуваарилалтыг гадаад валютын бодит орлогыг тогтвортой нэмэгдүүлэх чиглэлд хамгийн үр ашигтай байх хувилбараар зохион байгуулж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт,</p> | <p>вагон болон Засгийн газрын 2025 оны 103 дугаар тушаалын дагуу "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн эзэмшлийн 400 вагоныг түрээсээр авч, нийт 565 хагас вагоноор Монгол улс, БНХАУ 2 улсын засгийн газрын хооронд байгуулсан хэлэлцээрийн хүрээнд Чайна энержи коксжих нүүрс /Тяньжин/ ХХК-ийн экспортын нүүрсийг Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн биржийн нүүрсийг Тавантолгой-Ханги, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн тээвэрлэлтэд тус тус ашиглаж байна. Түүнчлэн МТЗ ТӨХК Зам, тээврийн сайдын 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн шуурхай хуралдаанаас өгсөн үүргийн дагуу нийслэлийн өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд "Тавантолгой түлш" ХХК-ийн 130,000 тонн түүхий нүүрс болох мидлингийг Тавантолгой-Зүүнбаян-Баян чиглэлд тээвэрлэхэд өөрийн эзэмшлийн 150 хагас вагоноор тээвэрлэлтийг гүйцэтгэхээр бэлтгэл ажил хангагдсан.</p> | | |
|--|--|--------------------------------------|--|---|--|--|

| | | | | | | |
|-----|-----|---|---|--|-----|------|
| | | | “Эрдэнэс Монгол” ХХК (С.Наранцогт)-Д; | | | |
| 135 | 218 | 2023 оны 7 дугаар сарын 5-ны өдөр 28 дугаар тэмдэглэл 2023-07-05 Дугаар 2023_28 | 1.8. Бодь интернэйшнл компани төмөр замын зүтгүүр оруулж ирэх хуваарийг нарийн гаргаж өгөх, хуваарийн дагуу “Монголын төмөрзам” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК ажлаа уялдуулах | Тавантолгой төмөр зам ХХК-ийн төслийн ерөнхий гүйцэтгэгч Бодь интернэйшнл ХХК нь төслийн хэмжээнд нийлүүлэгдэх 16 ширхэг гол замын SD70Aсе загварын илчит тэрэгнүүдийг 2024 онд "Тавантолгой төмөр зам" ХХК-д хүлээлгэн өгсөн. | ХБГ | 100% |
| 136 | 220 | 2023 оны 7 дугаар сарын 19-ний өдөр 29 дүгээр тэмдэглэл 2023-07-19 Дугаар 2023_29 | IX.3.7. Сайжруулсан шахмал түлшний түүхий эд (мидлинг)-ийн төмөр замын тээвэрлэлтэд хөнгөлөлт үзүүлэх, тээвэрлэлтийн вагоны тоог нэмэгдүүлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, “Эрдэнэс Тавантолгой” ХК | Монгол Улсын Засгийн газар, “Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо”-ны 2025 оны 01 дүгээр сарын хамтарсан хурлын шийдвэр, Тавантолгой түлш ХХК-аас ирүүлсэн 2025 оны 01 дүгээр сарын 07 өдрийн 01/16 дугаар албан бичгийн дагуу 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс хойш мидлингийн тээвэр 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл түр хугацаагаар зогссон. Мөн тус албан бичгийн хавсралтаар 2025 оны 06 дугаар сараас 2026 оны 05 дугаар сар хүртэлх тээвэрлэлтийн урьдчилсан төлөвлөгөөг явуулсан, 2025 оны 07.30-ны өдрийн 04/864 дугаартай албан бичгээр 130,000 тонн нүүрс татан татах тухай мэдэгдсэн боловч одоог хүртэл тээвэрлэлт эхлүүлээгүй байна. МТЗ ТӨХК Зам, тээврийн сайдын 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн шуурхай хуралдаанаас өгсөн үүргийн дагуу нийслэлийн өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд "Тавантолгой түлш" ХХК-ийн 130,000 тонн түүхий нүүрс болох мидлингийн тээвэрлэлтийг Тавантолгой-Зүүнбаян-Баян чиглэлд өөрийн эзэмшлийн 150 хагас вагоноор гүйцэтгэхээр бэлтгэл ажлаа хангаад байна. "Тавантолгой түлш" ХХК нь 2025 оны 01 дүгээр сард 37,638 тонн мидлингийг тээвэрлэсэн байна. | ТУГ | 100% |

| | | | | | | |
|-----|-----|--|--|---|-------|------|
| | | | дахь Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат нарт;; | | | |
| 144 | 231 | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 49 дүгээр тэмдэглэл 2023-12-06 Дугаар 2023_49 | XVI.3.4. Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 66 хувийн хувьцаа эзэмшигч “Эрдэнэс Тавантолгой” ХК болон 34 хувийн хувьцаа эзэмшигч “Монголын төмөр зам” ТӨХК-ууд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын цогцолбор төслийн хөрөнгө оруулалтыг тус тусын эзэмшиж буй хувьцаанд ногдох дүнгээр санхүүжүүлэх зарчмыг баримтлан холбогдох санхүүжилтийн гэрээг хууль тогтоомжид нийцүүлэн байгуулахыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (У.Бямбасүрэн), “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү)-д; | “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн хооронд “ЭТТ-2019/731 дугаартай үнэт цаас худалдах, худалдан авах гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой хамтын ажиллагааны гэрээний нэмэлт, өөрчлөлт”-ийг 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр байгуулсан. Тус гэрээгээр “Монголын төмөр зам” ТӨХК-ийн эзэмшиж байгаа “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 34 хувийн хувьцааг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн гаргасан 750.0 /долоон зуун тавин тэрбум/ төгрөгийн бондоос суутган тооцох замаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-д шилжүүлж санхүүгийн тайлан, балансад холбогдох бүртгэлийг тусгаж бондын үлдэгдэл 56.2 тэрбум төгрөгийг буцаан төлөх хуваарийг гэрээний хавсралтаар баталсан. | СНББХ | 100% |

| | | | | | | |
|-----|------|---|---|--|-------|-------------------|
